



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ-2016

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2017 он



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ- 2016 СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны багийн бүрэлдэхүүн

Судалгааны Зөвлөх: Л.Отгонтуяа, “Төсвийн удирдлагын хүрээлэн” ТББ-ын захирал, Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор

Судалгааны зохицуулагч: Д.Оюунбадам, Нээлттэй Нийгэм Форумын Эдийн засгийн хөтөлбөрийн менежер

Хөндлөнгийн үнэлгээний багийн гишүүд:

- Л.Отгонтуяа, “Төсвийн удирдлагын хүрээлэн” ТББ-ын захирал, Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор
- Д.Цэрэнжав, “Ил тод байдал сан” ТББ-ын Гүйцэтгэх захирал
- Д.Оюунцэцэг, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор

© Нээлттэй Нийгэм Форум 2017

Энэхүү судалгааны тайланг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14240
Монгол улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Цахим хуудас: www.forum.mn
Цахим шуудан: osf@forum.mn

Агуулга

Товчилсон үг	4
Өмнөх үг	8
НЭГ. Оршил	10
1.1. Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээний явц, онцлог	11
1.2. Орон нутгийн төсвийн ил тод байдалд тавигдах шаардлага	13
ХОЁР. Орон нутгийн төсвийн ил тод байдал	16
2.1. Аймаг, нийслэл, дүүргийн нэгдсэн дүн	16
А. Аймаг нийслэлийн төсвийн ил тод байдал	16
Б. Дүүргүүдийн төсвийн ил тод байдал	21
2.2. Төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдал	22
2.2.1. Төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгаж зохицуулсан байдал	22
2.2.2. Төсвийн үйл явц, баримт бичгүүдийн ил тод байдал	29
ГУРАВ. Дүгнэлт, бодлогын зөвлөмж	52
Хавсралтууд	55
Хавсралт 1. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээний нэгтгэл–2016	56
Хавсралт 2. Дүүргийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээний нэгтгэл–2016	58
Хавсралт 3. Орон нутаг тус бүрийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дүн /21 аймаг, нийслэл, 9 дүүрэг/	59
Хавсралт 4. Орон нутгийн төсвийн баримт бичгүүд болон төсвийн үйл явцын нээлттэй, ил тод байдлыг үнэлэхэд ашиглах шалгуур үзүүлэлт, түүнд харгалзах оноо	245
Хавсралт 5. Асуулга	246
Хавсралт 6. Судалгааны багийн талаарх мэдээлэл	273

Товчилсон үг

ДАХШУ	Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ
ДАХШҮТ	Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний тасаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
ОНТИТБ	Орон нутгийн төсвийн ил тод байдал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТББ	Төрийн бус байгууллага
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ҮДГ	Үр дүнгийн гэрээ
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХШҮ	Хяналт шинжилгээ, үнэлгээ
ШДТХ	Шилэн дансны тухай хууль
ШДЦХ	Шилэн дансны цахим хуудас
ШДЦХТМАСТЖ	Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, стандартыг тогтоох журам

Аймаг, нийслэлийн нэрийн товчлол

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БХ	Баянхонгор
БУ	Булган
ГА	Говь-Алтай
ГС	Говьсүмбэр
ДА	Дархан-Уул
ДГ	Дорноговь
ДО	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ОР	Орхон

ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
УБ	Улаанбаатар

Дүүргүүдийн нэрийн товчлол

БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
НД	Налайх дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын индекс тооцсон байдал, хувиар	17
Хүснэгт 2. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын 2011, 2013, 2016 оны үнэлгээний харьцуулалт	20
Хүснэгт 3. Дүүргүүдийн төсвийн ил тод байдлын үнэлгээ, хувиар	21
Хүснэгт 4. Төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээ	23
Хүснэгт 5. Аймаг, нийслэлийн төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдлын үнэлгээний харьцуулалт, 2013, 2016 он	30
Хүснэгт 6. Аймаг, нийслэлийн 2015 оны 6–12 дугаар сар, 2016 оны 1–5 дугаар сарын худалдан авалтын явц, үр дүнгийн ил тод байдал, хувиар	42
Хүснэгт 7. Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлын үнэлгээний харьцуулалт, хувиар	47
Хүснэгт 8. Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны ОНХС-ийн ил тод байдал, хувиар	48

Графикийн жагсаалт

График 1.	Төсвийн ил тод байдлаар аймаг, нийслэлийн эзэлсэн байр 2011–2016	19
График 2.	Орон нутгийн төсвийн ил тод байдлын дундаж үнэлгээ, хувиар	20
График 3.	Нутгийн удирдлагын байгууллагын эрх зүйн баримт бичгүүдэд төсвийн ил тод байдал тусгагдсан байдлын дундаж үнэлгээ, хувиар	24
График 4.	Орон нутгийн төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдлын үнэлгээ, хувиар	29
График 5.	Аймаг, нийслэлийн төсвийн төслийн ил тод байдал, хувиар	31
График 6.	Дүүргийн төсвийн төслийн ил тод байдал, хувиар	32
График 7.	Аймаг, нийслэлийн 2016 оны төсөв хэлэлцэн баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдал, хувиар	33
График 8.	2016 оны төсвөө хэлэлцэн баталсан дүүргүүдийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал, хувиар	34
График 9.	Аймаг, нийслэлийн төсвийн төсөл хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдлын үнэлгээний нэгтгэсэн дүн хувиар, 2013, 2016 оны харьцуулалт	35
График 10.	Дүүргийн 2016 оны төсвийн төсөл хэлэлцэж, баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдал, хувиар	36
График 11.	Аймаг, нийслэлийн төсөв хэлэлцэж, баталсан хуралдааны баримт бичгийн ил тод байдал, хувиар (2013, 2016 оны харьцуулалт)	36
График 12.	Дүүргийн 2016 оны төсөв хэлэлцэж, баталсан хуралдааны баримт бичгийн ил тод байдал, хувиар	37
График 13.	Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны батлагдсан төсвийн ил тод байдлын үнэлгээ, хувиар	38
График 14.	Аймаг, нийслэлийн төсвийн тодотголын ил тод байдлын үнэлгээ, хувиар	40
График 15.	Дүүргийн төсвийн тодотголын ил тод байдлын үнэлгээ, хувиар	41
График 16.	Аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал, хувиар	41
График 17.	Дүүргийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал, хувиар	44
График 18.	Аймаг, нийслэлийн төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлын харьцуулалт, хувиар	45

Өмнөх үг

Сүүлийн жилүүдэд орон нутгийн төсвийн зарлага нэлээд өсөж байгаа билээ. Тухайлбал, нийт зарлага 2013 онд 1.8 орчим их наяд төгрөг байсан бол 2016 онд 2.2 их наяд төгрөг буюу нэгдсэн төсвийн нийт зарлагын 27 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 8 хувьд хүрчээ. Иймд өсөн нэмэгдэж буй төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөв захиран зарцуулагчдын хариуцлагыг дээшлүүлэхэд орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах нь нэн чухал үүрэгтэй юм.

Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын 2011 оноос эхлэн хоёр жил тутамд хийж буй орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгааны дүн төсвийн ил тод байдал хангалтгүй байгааг харуулж ирлээ. 2013 онд хийгдсэн хоёр дахь удаагийн судалгаанаас хойш Шилэн дансны тухай хууль батлагдаж төсвийг ил тод болгох, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй төр засгийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох хууль эрх зүйн орчин бүрдсэн билээ. Иймд орон нутагт уг хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж, төсвийн ил тод байдалд бодит өөрчлөлт гарч буй эсэхийг тодорхойлох зорилгоор орон нутгийн төсвийн ил тод байдлын ээлжит үнэлгээг 2016 онд гурав дахь удаагаа дахин хийж, судалгааны тайланг уншигч Танд толилуулж байна.

Энэ удаагийн судалгааны хүрээнд 21 аймаг, нийслэлээс гадна нийслэлийн 9 дүүрэгт төсвийн ил тод байдлын түвшин ямар байгааг үнэллээ. Үнэлгээг орон нутгийн төсвийн ил тод байдалд тавигдах шаардлагыг тодорхойлж буй Төсвийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан журмуудын дагуу ил тод болговол зохих төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгүүдийг 2015 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс 2016

оны 6 дугаар сарын 1-нийг хүртэлх нэг жилийн хугацаанд хэрхэн ил тод болгосон байдалд үндэслэн хийв. Судалгааны дүнгээр аймаг, нийслэлийн хувьд төсвийн ил тод байдал дунджаар 39 хувьтай гарч өмнөх түвшнээс зөвхөн гурван хувиар л дээшилжээ. Цаашилбал, дүүргүүдийн төсвийн ил тод байдлын дундаж үнэлгээ 31 хувьтай байна. Энэ нь Шилэн дансны тухай хууль батлагдаж, төсвийн ил тод байдлыг хангах хууль эрх зүйн зохицуулалт сайжирсан боловч хууль, тогтоомжийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй түвшинд байгааг илтгэж байна.

Нийт аймаг, нийслэл хот, дүүргийг хамарсан энэхүү судалгааг хийж гүйцэтгэсэн 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг, ялангуяа судалгааг удирдан явуулсан Төсвийн удирдлагын хүрээлэнгийн захирал Л.Отгонтуяа, Ил тод байдал сангийн Гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав болон ННФ-ын Эдийн засгийн бодлогын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам нарт гүн талархал илэрхийлье.

Орон нутгийн төсвийн ил тод байдлыг иж бүрэн үнэлсэн энэхүү судалгааны дүн нь төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах талаар олон нийт, бодлого боловсруулагчид, орон нутгийн удирдлагуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

П. Эрдэнэжаргал
Нээлттэй Нийгэм Форумын
Гүйцэтгэх захирал

НЭГ. Оршил

Нутгийн удирдлагын байгууллагуудын төсөв, санхүүгийн ил тод байдлыг тодорхойлох арга хэрэгсэл нь орон нутгийн төсвийн үнэлгээ юм. Орон нутгийн төсөв нь дангаараа Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогын 35 хувь, нийт зарлагын 30 орчим хувьтай тэнцдэг. Иймээс энэ төсвийн ил тод байдлыг судалж, түүний баримт бичиг, үйл явцын ил тод байдлын индексийг тооцох нь төсвийн мэдээллийн ил тод байдал, энгийн ойлгомжтой байдлыг хянаж үнэлэхэд чиглэхийн зэрэгцээ төсвийн үйл явцад иргэдийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх, төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Индексийг тооцсоноор зөвхөн төсвийн ил тод байдлын түвшинг хэмжиж, түүнийг хянаж үнэлээд зогсохгүй төсвийн ил тод байдлыг сайжруулахад нутгийн удирдлагын зүгээс хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлоход тусалдаг.

Энэхүү судалгаа нь хоёр жил тутамд хийгддэг бөгөөд анх 2010–2011 онд Олон улсын төсвийн түншлэл байгууллагын Нээлттэй төсвийн санаачилгын санхүүгийн болон арга зүйн дэмжлэгтэйгээр Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-аас “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээтэй хамтран гүйцэтгэснээс хойш гурав дахь үнэлгээ гарч буй нь энэ юм. “Орон нутгийн төсвийн ил тод байдал–2016” судалгааг 21 аймаг, нийслэлээс гадна нийслэлийн 9 дүүргийг хамруулан өмнөх хоёр удаагийн үнэлгээнээс илүү өргөн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аймаг, нийслэл, дүүргийн орон нутгийн төсвийн ил тод байдал (ОНТИТБ)-ын энэхүү үнэлгээг 1) Төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдал; 2) Төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдал гэсэн хоёр чиглэлээр хийсэн болно.

Үнэлгээний тайланг дараах бүтэцтэйгээр боловсруулаа. Нэгдүгээр бүлэгт “Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээний явц, онцлог”-ийг тайлбарлахын зэрэгцээ “Орон нутгийн төсвийн ил тод байдалд тавигдах шаардлага”-ыг Төсвийн тухай болон Шилэн дансны тухай хуулиудад нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэрт тулгуурлан тодорхойлов. “Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дүн” гэсэн хоёрдугаар бүлэгт “Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ил тод байдлын нэгдсэн дүн”, “Төсвийн үйл явц, баримт бичгүүдийн ил тод байдлын үнэлгээ”-г дэлгэрэнгүй танилцуулсан бол гуравдугаар бүлэгт судалгааны дүнд тулгуурлан гаргасан дүгнэлт болон бодлогын зөвлөмжийг багтаав. Түүнчлэн Төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдал, Төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдлыг аймаг, нийслэл, дүүргүүдээр нэгтгэсэн дүн болон орон нутаг тус бүрээр гаргасан төсвийн ил тод байдлын үнэлгээг Хавсралтад нэг бүрчлэн харуулаа.

1.1. Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээний явц, онцлог

Монгол Улсад орон нутгийн төсвийн ил тод байдлыг иж бүрнээр нь үнэлэх анхны судалгааг ННФ 2011 онд хийсэн бөгөөд тэр үед Төсвийн тухай хууль шинээр батлагдсан ч хэрэгжиж эхлээгүй байсан юм. Уг судалгааг Олон улсын төсвийн түншлэл байгууллагын арга зүйд тулгуурлан гүйцэтгэсэн ч өөрийн орны онцлог нөхцөлд нийцсэн зарим асуудлыг жишээлбэл, төсвийн баримт бичгийг судалгааны асуулгад нэмж оруулан боловсруулснаас гадна орон нутагт ажилладаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл судалгааны асуулгын дагуу мэдээлэл цуглуулж, нотлохоос эхлээд өгөгдсөн хариултаас сонгож үнэлгээ дүгнэлт хийх үүрэг хүлээж ажилласан билээ. Энэ нь “Иргэд төсвөө хянана” сүлжээний орон нутгийн гишүүн байгууллагуудын хувьд хамтран гүйцэтгэсэн анхны томоохон судалгаа төдийгүй төсвийн мэдээлэл цуглуулах, түүнийг нотлох арга барилыг эзэмшихэд нь бодитой нөлөө үзүүлсэн ач холбогдолтой ажил болжээ.

Харин Төсвийн тухай хууль (ТТХ), Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (МИТББМАЭТХ) батлагдаж төсөв, худалдан авах ажиллагаа, орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн ил тод байдлыг хангах чиглэлээр нарийвчлан зохицуулсан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, шийдвэр хэрэгжиж эхэлсэн шинэ

нөхцөл байдалд ННФ-аас “Орон нутгийн төсвийн ил тод байдал–2013” судалгааг “Иргэд төсвөө хянана” сүлжээний гишүүн байгууллагууд болон судлаачдын оролцоотойгоор хийсэн юм. Энэ судалгааны дүнгээр аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын дундаж үнэлгээ 2011 оныхоос нэгээр нэмэгдэж 36 хувьтай гарсан нь орон нутгийн төсвийн ил тод байдалд бодитой ахиц гарч чадаагүйг илтгэсэн болно.

Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлыг 2013 онд үнэлсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Улсын Их Хурал (УИХ)-д өргөн барьсан Шилэн дансны тухай хууль (ШДТХ) 2014 оны 7 дугаар сарын 15-ны өдөр батлагдан 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Уг хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан МИТББМАЭТХ-ийн төсөв, худалдан авах ажиллагааны ил тод байдалтай холбоотой заалтуудыг хүчингүй болгож ШДТХ-иар зохицуулах болсон юм. Үүнээс гадна Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг батлан улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд дагаж мөрдөх болсон билээ.

Ийнхүү төсвийн ил тод байдлын хууль, эрх зүйн зохицуулалт сайжирч, хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд буюу 2015 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэг жилийн хугацааг хамруулан “Орон нутгийн төсвийн ил тод байдал–2016” судалгааг хийж гүйцэтгэлээ. Судалгаанд аймаг, нийслэл, дүүргийн түвшинд ил тод болговол зохих төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг хамруулан ННФ, “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ хамтран ажиллав. Энэ удаагийн судалгаанд орон нутгийн судлаачид тухайн аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ил тод байдлын талаарх мэдээллийг 2016 оны 7 дугаар сараас 9 дүгээр сард цуглуулав. ННФ болон “Ил тод байдал сан” ТББ-ын судалгааны баг цуглуулсан мэдээллийг нягтлан боловсруулаа.

Орон нутгийн судлаачид нь ННФ-ын судалгааны багийн боловсруулсан асуулга буюу маягтын дагуу тухайн орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгүүдийг үндсэн эхээр нь хэрхэн ил тод, нээлттэй болгосныг баримтжуулан зохих нотолгоог бүрдүүлж судалгааны багт ирүүлэх үүрэгтэй ажиллаж дээрх баримт бичгийг дараах нээлттэй эх сурвалжийг ашиглан бүрдүүллээ. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудас
- Орон нутгийн сонин хэвлэл, телевиз, радио
- Орон нутгийн төр захиргааны албан ёсны болон бусад цахим хуудас
- Мэдээллийн хуудас, товхимол
- Мэдээллийн самбар
- Номын сан
- Иргэний танхим
- Интернэт болон бусад мэдээллийн төв
- Хэвлэлийн бага хурал
- Уулзалт, хэлэлцүүлэг
- Бусад эх сурвалж хамаарна.

Түүнчлэн төсвийн мэдээлэл ба баримт бичиг нь дээр дурдсан эх сурвалжаас олдоогүй тохиолдолд тухайн мэдээлэл, баримт бичгийг гаргасан байгууллага, албан тушаалтанд хандах шаардлагатай үед МИТБМАЭТХ-ийн холбогдох заалтын дагуу хүсэлт тавьж зохих мэдээллийг олж авч байв.

Орон нутгийн судлаачдын ирүүлсэн судалгааны маягтад үндэслэн ННФ-ын судалгааны багийн гишүүд аймаг, нийслэл, дүүргийн төсвийн баримт бичиг, үйл явцын ил тод байдлыг нэг бүрчлэн дахин нягталж, холбогдох цахим хуудсанд нэвтрэн нотолгоо, баримтад тулгуурлан хараат бусаар үнэлгээ өгч “Орон нутгийн төсвийн ил тод байдал-2016” судалгааны дүнг нэгтгэн гаргалаа.

1.2. Орон нутгийн төсвийн ил тод байдалд тавигдах шаардлага


Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангахад тавигдах шаардлагыг дараах хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журмуудад тодорхойлсон байдаг. Үүнд:

- Төсвийн тухай хууль (2011)
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2010)
- Шилэн дансны тухай хууль (2014)
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005)

- Дээрх хуулиудад нийцүүлэн гаргасан журмууд (Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”, Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2012 оны 264-р тушаалаар багтлагдсан “Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, 2012 оны 290-р тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”, 2012 оны 239-р тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”, Сангийн сайдын 2010 оны 45-р тушаалаар батлагдсан “Хандив тусламжийг бүртгэх журам”-ыг дурдаж болно).

Эдгээр хууль, журамд үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн түвшинд ил тод болговол зохих баримт бичиг, үйл явц тус бүрийг эрх зүйн зохицуулалтад тусгасан хугацаанд, заагдсан хэлбэрээр, зохих газарт нь ил тод болгосон эсэхийг тодорхойлов. Түүнчлэн орон нутгийн төсвийн үйл явц, баримт бичгүүдийн талаарх мэдээллийн иж бүрэн байдлыг үнэлэв. Нийтдээ 12 үйл явц, баримт бичгийн ил тод байдлыг үнэллээ (Зураг 1).

Зураг 1. Орон нутгийн төсвийн ил тод байдлыг үнэлэх үзүүлэлт



Орон нутгийн төсвийн үйл явц, төсвийн мэдээллийн ил тод байдалд тавигдах эрх зүйн шаардлагыг энэхүү тайлангийн Хавсралтад тусгагдсан судалгааны асуулга буюу маягтаас үзэх боломжтой.

ХОЁР. Орон нутгийн төсвийн ил тод байдал

2.1 Аймаг, нийслэл, дүүргийн нэгдсэн дүн

Орон нутгийн буюу аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ил тод байдлын үнэлгээ нь “Төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдал”, “Төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдал” гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Нэгдсэн үнэлгээг гаргахдаа төсвийн ил тод байдлыг эрх зүйн баримт бичигт тусгасан байдал болон төсвийн үйл явц, баримт бичгүүдийн ил тод байдлыг харуулах нийт 12 үзүүлэлтийн дундаж үнэлгээгээр тооцсон болно. Ийнхүү гаргасан үнэлгээг нэгтгэхдээ 21 аймаг, нийслэлийг хооронд нь, нийслэлийн 9 дүүргийг хооронд нь тус тус харьцуулав.

А. Аймаг нийслэлийн төсвийн ил тод байдал

Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлыг үнэлсэн судалгааны дүнг нэгтгэн эрэмбэлж Хүснэгт 1-д харуулав.

Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээг аймаг, нийслэлийн дунджаар тооцвол нийт авбал зохих 100 хувиас 39.0 авсан нь орон нутгийн төсвийн ил тод байдал хангалттай түвшинд хүрч чадаагүй байгааг харуулна. Аймгуудаас Хөвсгөл хамгийн өндөр буюу 58.5 хувьтай үнэлэгдсэн бол Баян-Өлгийн үнэлгээ 20.8 хувьтай гарчээ.

Хүснэгт 1. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын индекс тооцсон байдал, хувиар

№	Үзүүлэлтүүд	Эрх зүйн баримт бичиг	Төсвийн төсөл	ИТХ-ын хуралдаан	Батлагдсан төсөв	Иргэний төсөв	Төсвийн тодотгол	Хөрөнгө оруулалт, худалдан авах ажлагаа	Төсвийн гүйцэтгэл	Орон нутгийн хөгжлийн сан	Засаг даргын нөөц хөрөнгө	Орон нутгийн тусгай сангуу	Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт	Нэгдсэн үнэлгээ	Рейтинг
1	Хөвсгөл	58	45	91	82	0	50	65	82	17	50	75	88	58.5	Дунджаас дээш
2	Сэлэнгэ	63	29	59	77	0	50	63	76	47	100	58	25	53.9	
3	Говьсүмбэр	50	31	38	68	0	31	73	68	38	75	75	63	50.8	
4	Увс	44	31	60	71	0	63	59	61	17	0	75	75	46.3	
5	Сүхбаатар	50	15	53	32	0	31	54	82	22	50	75	87	45.9	
6	Говь-Алтай	28	31	46	77	0	63	50	71	36	42	75	13	44.3	
7	Завхан	41	34	47	39	0	38	36	39	42	50	75	88	44.1	
8	Өмнөговь	65	28	45	77	0	56	67	75	31	25	25	0	41.2	Дундаж
9	Улаанбаатар	40	19	62	54	0	62	39	57	19	0	50	88	40.8	
10	Баянхонгор	25	5	50	71	0	63	50	80	13	25	50	38	39.2	
11	Өвөрхангай	51	4	50	69	0	44	58	52	4	0	50	75	38.1	
12	Төв	49	10	59	65	0	44	51	69	21	0	42	46	38.0	
13	Орхон	34	16	30	43	0	19	48	71	25	25	75	62	37.3	
14	Дархан-Уул	44	21	47	55	0	6	35	62	29	25	25	88	36.4	
15	Хэнтий	38	10	47	57	0	37	62	68	38	0	75	0	36.0	Дунджаас доош
16	Ховд	13	22	55	61	0	31	45	61	8	0	75	50	35.1	
17	Булган	19	22	37	71	0	31	68	75	17	0	75	0	34.6	
18	Архангай	31	16	62	44	0	19	36	64	17	25	75	25	34.5	
19	Дорноговь	14	10	27	64	0	19	43	75	8	0	75	38	31.1	
20	Дорнод	25	12	42	43	0	25	57	54	0	0	25	37	26.7	
21	Дундговь	25	3	28	64	0	6	58	68	21	0	0	13	23.7	
22	Баян-Өлгий	25	15	5	43	0	13	33	33	8	0	67	8	20.8	
Дундаж оноо		37.8	19.5	47.3	60.3	0.0	36.5	52.3	65.6	21.7	22.4	58.7	45.9	39.0	

Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын үнэлгээг нэгтгэн харахад хамгийн өндөр нь 58.5, дундаж нь 36.0–41.2 хувь байгаа нь Хүснэгт 1-ээс харагдаж байна. Үнэлгээний дундаж үзүүлэлтэд үндэслэн аймаг нийслэлийн төсвийн ил тод байдлыг авч үзвэл “дунджаас дээш (44-өөс дээш хувьтай)” үнэлгээг 7 аймаг авсан бол “дундаж (36–41 хувьтай)” үнэлгээг Улаанбаатар хот болон 7 аймаг авч, харин 7 аймаг “дунджаас доош (20–35 хувьтай)” үнэлгээ авчээ. Үүнийг аймаг тус бүрээр ангилан Зураг 2-т харуулав.

Зураг 2. Орон нутгийн төсвийн ил тод байдлын рейтинг


Дунджаас дээш (>44 %)	Дундаж (36-41 %)	Дунджаас доош (20-35 %)
Хөвсгөл	Улаанбаатар хот	Ховд
Сэлэнгэ	Өмнөговь	Булган
Говьсүмбэр	Баянхонгор	Архангай
Увс	Өвөрхангай	Дорноговь
Сүхбаатар	Төв	Дорнод
Говь-Алтай	Орхон	Дундговь
Завхан	Дархан-Уул	Баян-Өлгий
	Хэнтий	

Энэ нь өмнөх судалгаануудын дүнгээс сайжраагүй буюу аймаг, нийслэлийн түвшинд төсвийн ил тод, нээлтэй байдал “хангалтгүй ба нэн хангалтгүй”¹ байгааг харуулна. Хэдийгээр зарим аймгууд тухайлбал, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Орхон аймгуудын төсвийн ил тод байдлын үнэлгээ хоёр дахь судалгааны үеэс буюу 2013 оныхоос 9–35 хувиар сайжирсан боловч Архангай, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Өмнөговь, Төв, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Ховд, Хэнтий аймгуудын үнэлгээ 1–17 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа юм. Харин Улаанбаатар хотын үзүүлэлт өмнөх судалгааны дүнгээс 2.1 хувиар дээшилсэн бол Увс аймгийнх 0.1 хувиар буурчээ. Өөрөөр хэлбэл, Шилэн дансны тухай хууль батлагдан хэрэгжиж, төсвийн ил тод байдлыг хангах хууль эрхзүйн зохицуулалт хангалттай түвшинд шинэчлэгдсэн боловч хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр аймаг, нийслэлийн хувьд дорвитой ахиц гараагүй байна (Хүснэгт 2).

2011, 2013, 2016 оны судалгаагаар аймгуудын эзэлсэн байрыг График 1-д харьцуулан харуулав.

1 Олон улсын жишгээр 26–60 хувь авахад “хангалтгүй”, 25-аас доош хувь авахад “нэн хангалтгүй” үзүүлэлт гэж тооцдог.

График 1. Төсвийн ил тод байдлаар аймаг, нийслэлийн эзэлсэн байр 2011-2016




Хүснэгт 2. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын 2011, 2013, 2016 оны үнэлгээний харьцуулалт (Нийт авбал зохих оноо: 100)

№	Аймаг, нийслэл	Орон нутгийн төсвийн ил тод байдал		
		2011	2013	2016
1	Архангай	44.5	36.8	34.6
2	Баян-Өлгий	32.3	26	20.8
3	Баянхонгор	32.4	15	39.1
4	Булган	44.6	36.5	34.6
5	Говь-Алтай	29.4	26.7	44.3
6	Говьсүмбэр	38.3	51.5	50.7
7	Дархан-Уул	25.5	35.2	36.4
8	Дорноговь	28.2	48.9	31.1
9	Дорнод	36.5	29.3	26.7
10	Дундговь	18	34.5	23.7
11	Завхан	37.4	27.1	44.1
12	Орхон	16.6	32.1	37.3
13	Өвөрхангай	37	27	38.1
14	Өмнөговь	29.7	44.5	41.2
15	Сүхбаатар	34.6	31.4	45.9
16	Сэлэнгэ	47.6	18.3	53.9
17	Төв	40.2	51.9	38
18	Увс	38.4	46.4	46.3
19	Ховд	48	47.1	35.1
20	Хөвсгөл	33.8	55.3	58.5
21	Хэнтий	19.9	37.1	36
22	Улаанбаатар	55.5	38.7	40.8
	Дундаж оноо	34.9	36.2	39

Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээг аймаг, нийслэлийн түвшинд дундажлан авч үзэхэд 2011 онд 34.9 хувь, 2013 онд 36.2 хувь байсан бол төсвийн ил тод байдлын эрх зүйн зохицуулалт хангалттай хэмжээнд бүрдэн хэрэгжиж байгаа 2016 оны байдлаар гурван жилийн өмнөхөөс 2.8 хувиар дээшилжээ (График 2).

График 2. Орон нутгийн төсвийн ил тод байдлын дундаж үнэлгээ, хувиар



Дээрх графикаас харахад аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдалд бага ч гэсэн ахиц гарч нутгийн удирдлагын зүгээс төсвийн үйл явц болон төсвийн баримт бичгийг ил тод, нээлттэй болгох алхмууд хийгдэж эхэлж байна.

Б. Дүүргүүдийн төсвийн ил тод байдал

Энэ оны судалгаанд нийслэлийн дүүргүүдийн төсвийн ил тод байдлын үнэлгээг бүрэн хамруулж, мөн төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдлыг аймаг, нийслэлийнхтэй нэгэн адилаар нэгтгэж гаргалаа (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Дүүргүүдийн төсвийн ил тод байдлын үнэлгээ, хувиар

№	Үзүүлэлт	Эрх зүйн баримт бичиг	Төсвийн төсөл	ИТХ-ын хуралдаан	Батлагдсан төсөв	Иргэний төсөв	Төсвийн тодотгол	Хөрөнгө оруулалт, ХАА	Төсвийн гүйцэтгэл	Орон нутгийн хөгжлийн сан	Засаг даргын нөөц хөрөнгө	Орон нутгийн тусгай сангууа	Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт	Нэгдсэн үнэлгээ	Рейтинг
1	Налайх	25	17	31	35	0	13	42	76	8	50	75	75	37.2	Дунджаас дээш
2	Баянзүрх	26	21	34	39	0	31	39	73	8	25	50	88	36.1	
3	Баянгол	39	13	38	67	0	19	34	81	0	0	75	63	35.6	
4	Хан-Уул	19	8	28	63	0	13	27	64	4	0	75	88	32.3	Дундаж
5	Сонгино-хайрхан	33	14	15	40	0	17	38	70	0	25	25	88	30.3	
6	Сүхбаатар	30	13	28	75	0	23	36	71	6	0	25	50	29.7	Дунджаас доош
7	Багануур	40	11	41	36	0	25	29	46	13	25	25	38	27.4	
8	Чингэлтэй	31	7	8	67	0	6	39	54	4	0	50	50	26.2	Дунджаас доош
9	Багахангай	39	25	10	42	0	19	33	73	21	0	0	38	24.8	
	Дундаж үнэлгээ (хувь)	31.3	14.2	25.6	51.4	0.0	18.3	35.1	67.6	7.1	13.9	44.4	63.9	31.1	

2016 оны байдлаар нийслэлийн 9 дүүргийн төсвийн ил тод байдлын дундаж үзүүлэлт 31.1 хувьтай буюу хангалтгүй түвшинд байна.

Хүснэгт 3-аас харахад дүүргүүдээс Налайх хамгийн өндөр буюу 37.2 хувьтай харагдаж байгаа хэдий ч энэ нь олон улсын жишигтэй

харьцуулахад “хангалтгүй” үнэлгээ юм. Бидний судалгаагаар гарсан дундаж хувь (29.7–32.3)-тай харьцуулан дүүргүүдийг бүлэглэвэл, Налайх, Баянзүрх, Баянгол дүүргүүд “дунджаас дээш” (35–37 хувь), Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд “дундаж” (29–32 хувь) үнэлгээ авсан бол Багануур, Чингэлтэй, Багахангай дүүргүүд “дунджаас доош” (24–27 хувь) үнэлгээ авчээ.

2.2. Төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдал

Энэ судалгааны ажлын нэг чухал хэсэг болох төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгаж зохицуулсан байдал, тэдгээрийг төсвийн үйл явцад хэрхэн ил тод болгож байгааг аймаг, нийслэл болон дүүргийн түвшинд авч үзлээ.

Үүнийг аймаг, нийслэл, дүүрэг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөр, ТЕЗ нартай байгуулсан үр дүнгийн гэрээ, дотоод хяналтын дүрэм журам зэрэгт хэрхэн тусгаснаар нь багцалж, хэрхэн хэрэгжүүлж байгаагаар нь тандан судлав.

2.2.1. Төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгаж зохицуулсан байдал

Судлаачид орон нутагт ажиллаж цуглуулсан мэдээлэл болон Шилэн дансны цахим хуудас, орон нутгийн албан ёсны цахим хуудсанд аймаг, нийслэл, дүүргээс нийтэлсэн мэдээлэлд тулгуурлан дараах 10 чиглэлээр нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт төсвийн ил тод байдлыг хэрхэн тусгасныг үнэлж дүнг нэгтгэн гаргалаа (Хүснэгт 4).²


2 Төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээний нэгтгэлийн дэлгэрэнгүйг Хавсралт 1, 2-оос үзнэ үү.

Хүснэгт 4. Төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээ

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Аймаг, нийслэлийн		Дүүргүүдийн	
		Дундаж хувь	Авсан оноо ³	Дундаж хувь	Авсан оноо
1	Орон нутгийн бодлогын баримт бичигт төсвийн ил тод байдлыг тусгасан эсэх (Тухайлбал, аймаг, нийслэл, дүүргийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилт)	62	2.5	74	2.9
2	Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ ба Тэргүүлэгчдийн хурлаас төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан тогтоол, шийдвэр	7	0.3	6	0.2
3	2016 онд аймаг, нийслэлийн Засаг даргын салбарын ТЕЗ нартай, Нийслэлийн Засаг даргаас дүүргийн Засаг дарга нартай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ	42	1.7	47	1.9
4	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	64	2.5	64	2.6
5	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан захирамж, албан даалгавар	49	2.0	29	1.2
6	Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын дарга болон байгууллагын төсвийн шууд захирагч нар Засаг даргатай байгуулсан ҮДГ-д тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	56	2.2	49	1.9
7	Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын даргын СТСХ-ийн даргатай байгуулсан ҮДГ-д тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	48	1.9	26	1.1
8	ЗДТГ-ын дарга болон СТСХ-ийн даргын гаргасан төсвийн ил тод байдалтай холбогдох албан бичиг, үүрэг даалгавар	22	0.9	8	0.3
9	Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ болон иргэдээс төсвийн ил тод байдалд тавих хөндлөнгийн хяналтын журам, түүний хэрэгжилт	9	0.4	0	0.0
10	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас төсвийн ил тод байдалд тавих дотоод хяналтын журам, түүний хэрэгжилт	20	0.8	10	0.4
Нэгдсэн үнэлгээ (дундаж)		38	1.5	31	1.3

3 Орон нутгийн төсвийн баримт бичгүүд болон төсвийн үйл явцын нээлтэй, ил тод байдлыг үнэлэхэд ашиглах шалгуур үзүүлэлт, түүнд харгалзах оноог Хавсралт 4-өөс үзнэ үү.

График 3. Нутгийн удирдлагын байгууллагын эрх зүйн баримт бичгүүдэд төсвийн ил тод байдал тусгагдсан байдлын дундаж үнэлгээ, хувиар



Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төсвийн ил тод байдалтай холбогдох заалт тусгагдсан байдал, Орон нутгийн бодлогын баримт бичигт тухайлбал, аймаг, нийслэл, дүүргийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудад төсвийн ил тод байдлыг тусгасан байдал зэрэг нь харьцангуй өндөр хувь (62–74)-тай байна. Харин Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн ил тод байдалд хяналт тавих үүрэг бүхий ИТХ-аас орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан тодорхой шийдвэр, ИТХ болон иргэдээс төсвийн ил тод байдалд хөндлөнгийн хяналт тавих журмыг одоогоор аймаг, нийслэл, дүүргийн түвшинд үндсэндээ гаргаагүй байгаа нь эдгээр үзүүлэлтийн үнэлгээ харьцангуй доогуур байгаагаас харагдана. Нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичгүүдэд төсвийн ил тод байдлыг хэрхэн тусгасныг доор товчлон харуулав.

Орон нутгийн бодлогын баримт бичигт тухайлбал аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилтыг тодорхойлсон баримт бичигт орон нутгийн төсвийн ил тод байдлын талаар тусгасан эсэхийг судалж үзэхэд ихэнх аймаг Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн ил тод байдлыг ханган ажиллах талаар тодорхой заалт тусгаж оруулсан байна. Говьсүмбэр, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Хөвсгөл, Хэнтий аймгууд болон Багахангай, Баянгол, Чингэлтэй дүүргүүд эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлдээ Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр ямар нэгэн зорилт тусгаж баталснаас гадна үндсэн чиглэлийг цахим хуудсандаа байршуулан иргэд, олон нийт чөлөөтэй олж үзэх боломжийг бүрдүүлжээ.

Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ ба Тэргүүлэгчдийн хурлаас төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан тогтоол, шийдвэр: Орон нутагт ажилласан судлаачдын цуглуулсан мэдээллээс үзэхэд Говьсүмбэр, Завхан, Орхон, Өмнөговь аймгууд, Налайх дүүрэг ИТХ болон Тэргүүлэгчдийн хурлаас төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой тогтоол шийдвэр гаргасан бол бусад аймаг, нийслэл, дүүрэг ийм шийдвэр гаргаагүй байна. Өмнөговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 50-р тогтоолоор Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Уг ажлын хэсэг 2016 оны 6 дугаар

сарын 25-ны өдрийн 92-р тогтоолоор “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн хууль хэрэгжүүлэгч байгууллагуудад зөвлөмж өгөх тухай тогтоолыг хүргүүлсэн байна.

2016 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 19-р тогтоолоор дээрх ажлын хэсгийг шинэчлэн байгуулжээ. Эдгээр тогтоол, шийдвэрийг ИТХ-ын болон орон нутгийн цахим хуудсанд ил тод болгоогүй боловч орон нутгийн судлаач холбогдох хүмүүстэй уулзаж, мэдээллийг нотлох баримтаар олж авч энэхүү судалгаанд оруулав. Налайх дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын төлөвлөгөө баталсан тогтоолд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай тусгажээ (*nalaikh.ub.khural.mn/n/9esyn*).

2016 онд аймаг, нийслэлийн Засаг дарга нар салбарын ТЕЗ нартай, Нийслэлийн Засаг даргаас дүүргийн Засаг дарга нартай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ: Төлөөлөн гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээнд Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ аймгууд мөн Нийслэл, Багануур, Баянгол, Багахангай дүүргүүдийн хувьд Шилэн дансны болон төсвийн ил тод байдлыг ханган ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах талаар дор хаяж нэг заалт оруулсан байгааг дурдах нь зүйтэй.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт: Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл аймгууд, Багахангай, Чингэлтэй дүүргүүд орон нутгийн албан ёсны цахим хуудсандаа бүрэн эхээр нь байршуулж, төсвийн ил тод байдлыг хангах талаар заалт тусгасан байна. Тухайлбал, Дархан-Уул аймаг Засаг даргын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 7 дахь заалтад “Төсвийн ил тод байдлыг хангаж, тогтвортой бие даасан байдлыг бэхжүүлэн орон нутгийн эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого баримталж ажиллана” гэж оруулжээ. Харин Багахангай, Чингэлтэй дүүргүүдийн хувьд “Төсвийн ил тод байдлыг хангана”, “Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан, төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээ тайланг олон нийтэд нээлттэй мэдээлнэ” гэсэн заалтыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байна.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан захирамж, албан даалгавар: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдал, хяналтыг сайжруулах тухай тодорхой агуулга, заалт бүхий захирамж, албан даалгаврыг Баян-Өлгий, Өвөрхангай, Сэлэнгэ аймгууд, Баянгол, Сүхбаатар дүүргүүдийн Засаг дарга гаргаж, орон нутгийн цахим хуудсанд нийтэлсэн бөгөөд иргэд, олон нийт олж үзэх боломжийг бүрдүүлсэн байна.

Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын дарга болон байгууллагын төсвийн шууд захирагч нар Засаг даргатай байгуулсан ҮДГ-д тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт: Үр дүнгийн гэрээг түвшин бүрт байгуулж, түүнд төсвийн ил тод байдлыг хангах талаар тодорхой хэмжээгээр тусгасан хэдий ч орон нутгийн болон байгууллагын цахим хуудсанд үндсэндээ ил тод болгоогүй. Харин нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Боловсролын хэлтсийн цахим хуудсанд дүүргийн Засаг дарга төсвийн шууд захирагч нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгах заалтуудыг нийтэлсний 1.6 дахь заалтад “... бүх мэдээллийг олон нийтэд ил тод байхаар Шилэн дансны хуулийг хэрэгжүүлнэ” гэж тусгажээ (sxd.edub.edu.mn/аргуулга/dfjgj).

Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын даргын СТСХ-ийн даргатай байгуулсан ҮДГ-д тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт: ЗДТГ-ын СТСХ-ийн даргын үр дүнгийн гэрээ хаана ч нийтэд ил тавигдаагүй байв. Иймээс орон нутгийн судлаачид ихэвчлэн албан тушаалтанд хүсэлт тавьж олж авчээ. Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий аймгууд болон Багахангай дүүргийн СТСХ-ийн даргын үр дүнгийн гэрээнд “Шилэн дансны тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлж, төсвийн ил тод байдлыг ханган ажиллах, дүүргийн төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэх гэсэн заалт тусгагджээ.

ЗДТГ-ын дарга болон СТСХ-ийн даргын гаргасан төсвийн ил тод байдалтай холбогдох албан бичиг, үүрэг даалгавар: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай албан бичиг, тоот, зөвлөмжийг ЗДТГ-ын дарга, СТСХ-ийн даргаас төсвийн байгууллагууд, сумдын Засаг дарга нарт Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгууд, Багануур дүүрэг хүргүүлснийг холбогдох албан тушаалтнуудад хүсэлт тавих замаар орон нутгийн судлаачид олж авчээ.

Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ болон иргэдээс төсвийн ил тод байдалд тавих хөндлөнгийн хяналтын журам, түүний хэрэгжилт: 2016 оны эхний хагас жилийн байдлаар аймаг, нийслэл, дүүргүүдийн ИТХ болон иргэдээс төсвийн ил тод байдалд тавих хөндлөнгийн хяналтын журам баталж, мөрдөөгүй байна. Харин Сүхбаатар аймгийн “Сэтгэшгүй Оюундалай” ТББ-аас төсвийн болон төрийн худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй, өрсөлдөөнтэй байдлыг олон нийтийн оролцоотой үнэлэх зорилгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой хяналт хийх, тайлагнах журам” боловсруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлуулжээ. ИТХ-ын тогтоол, журмыг khural.mn сайт sukhbaatar.khural.mn/n/etao-д нийтэлсэн боловч иргэдийн бүлгийг чадавхжуулах хөрөнгө мөнгөний асуудал шийдэгдээгүйн улмаас энэ чиглэлээр хяналтын ажил хийж эхлээгүй байна.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас төсвийн ил тод байдалд тавих дотоод хяналтын журам, түүний хэрэгжилт: Говьсүмбэр, Өмнөговь аймгууд, Багануур дүүргээс бусад орон нутагт энэ үзүүлэлт маш хангалтгүй түвшинд байна. Говьсүмбэр аймгийн Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний тасаг (ДАХШҮТ)-аас 2015 онд хийх Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ (ДАХШҮ)-ний нэгдсэн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн мэдээллийг PDF форматаар аймгийн албан ёсны цахим хуудсанд 2016 оны 5 дугаар сарын 31-нд байршуулжээ. Төлөвлөгөөний 17-д “Төрийн байгууллагуудын ил тод байдалд сар бүр хяналт тавих” ажлыг оруулсан бөгөөд 100 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн байна. Аймгийн төрийн байгууллагуудад 2015 онд хийсэн Хяналт шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний үр дүн болох 80 хуудас материалыг Говьсүмбэр аймаг албан ёсны цахим хуудсандаа PDF форматаар татаж авах боломжтойгоор байршуулжээ. Мөн Багануур дүүргийн Дотоод аудитын хяналт шалгалтын удирдамжийг дүүргийн цахим хуудсанд нийтэлсэн бөгөөд уг журмын “хамрах хүрээ” хэсэгт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг багтаасан байв.

Товч дүгнэхэд, төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын нэгдсэн үнэлгээ аймаг, нийслэлийн түвшинд 38, дүүргүүдийн түвшинд 31 хувьтай тус тус

гарсан нь олон улсын жишигтэй харьцуулахад “хангалтгүй” үнэлгээ юм. Энэ нь орон нутгийн ИТХ, Засаг даргын зүгээс төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр дүрэм журам тогтоох, хяналт тавих чиглэлээр бодитой алхмуудыг хийх шаардлагатай байгааг харуулж байна.

2.2.2. Төсвийн үйл явц, баримт бичгүүдийн ил тод байдал

Төсвийн үйл явц, баримт бичгүүдийн ил тод байдал аймаг, нийслэлийн болон дүүргүүдийн түвшинд харилцан адилгүй байна (График 4). Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн үйл явц, баримт бичгүүдийн ил тод байдлыг үнэлж үзэхэд төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл харьцангуй нээлттэй буюу аймаг, нийслэлийн түвшинд 66 хувь, дүүргүүдийн түвшинд 68 хувьтай байна. Харин батлагдсан төсөв, орон нутгийн тусгай сангууд, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны мэдээлэл аймаг, нийслэлийн түвшинд 50-иас дээш хувьтай ил тод болжээ. Дүүргүүдийн түвшинд хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, батлагдсан төсвийн мэдээлэл 50-иас дээш хувиар нийтэд ил тод болсон байна.

График 4. Орон нутгийн төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдлын үнэлгээ, хувиар



Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төсөл, төсвийн тодотгол, Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС), Засаг даргын нөөц хөрөнгийн мэдээллийг олон нийтэд маш хангалтгүй мэдээлсэн байна.

Төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдлыг 2013 оныхтой харьцуулж үзэхэд ОНХС, Засаг даргын нөөц хөрөнгө болон Төсвийн тодотголын мэдээллийн ил тод байдал аймаг, нийслэлийн түвшинд тун хангалтгүй байв (Хүснэгт 5). Үүний учир нь Шилэн дансны тухай хуульд ил тод байдлын шаардлага нь тодорхой тусгагдаагүй үйл явц, баримт бичгүүд байгааг анхаарах шаардлагатай.

Хүснэгт 5. Аймаг, нийслэлийн төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдлын үнэлгээний харьцуулалт, 2013, 2016 он

№	Төсвийн баримт бичгийн нэр	Ил тод байдлын үнэлгээ (хувиар)		
		2013 он	2016 он	Зөрүү
1	Эрх зүйн баримт бичиг	39.0	37.7	-1.3
2	Төсвийн төсөл	15.3	19.6	4.3
3	ИТХ-ын хуралдаан	46.0	47.1	1.1
4	Батлагдсан төсөв	48.8	60.4	11.6
5	Иргэний төсөв	1.1	0.0	-1.1
6	Төсвийн тодотгол	41.5	36.4	-5.1
7	Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа	50.9	52.3	1.4
8	Төсвийн гүйцэтгэл	55.6	65.6	10.0
9	Орон нутгийн хөгжлийн сан	38.5	21.7	-16.8
10	Засаг даргын нөөц хөрөнгө	30.2	22.3	-7.9
11	Орон нутгийн тусгай сангууд	43.4	58.7	15.3
12	Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт	16.8	45.6	28.8

Дээрх хүснэгтээс харахад төсвийн нийт 12 үйл явц, баримт бичгээс 7 мэдээллийн ил тод байдлын үзүүлэлт нь дээшилсэн байна. Үүнд Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, Орон нутгийн тусгай сангууд, Батлагдсан төсөв, Төсвийн гүйцэтгэлийн мэдээллийн ил тод байдал харьцангуй дээшилжээ (10–28 хувиар). Харин Төсвийн төсөл, ИТХ-ын хуралдаан, Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал өмнөх түвшнээс буураагүй (1.1–4.3 хувиар нэмэгдсэн) хэдий ч үнэлгээ нь төдийлөн өссөнгүй.

2016 оны төсвийн үйл явц, баримт бичиг тус бүрийн ил тод байдлын үнэлгээг аймаг, нийслэл, дүүргээр харьцуулан гаргав.

Төсвийн төслийн ил тод байдал


Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг дарга нь Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.3 дахь заалтад

тусгагдсан цаглабарын дагуу дараа жилийн төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх бөгөөд Шилэн дансны тухай хуулийн 6.1.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 3.1.16 дахь заалтын дагуу жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор нийтэд мэдээлэх үүрэгтэй. Гэтэл эдгээр журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Төсвийн үйл явц, баримт бичгүүдээс төсвийн төслийн ил тод байдлын үнэлгээ аль ч түвшинд доогуур байна.

Судалгаагаар аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийн баримт бичгийн ил тод байдлыг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн санал болон аймаг, нийслэлийн аудитор, ИТХ-д өргөн мэдүүлсэн орон нутгийн төсвийн төслийг олон нийтэд хэр нээлттэй мэдээлсэн эсэхийг харгалзан үнэлэв. Аймаг, нийслэл тус бүрийн холбогдох баримт бичгийн нээлттэй байдлыг эдгээр үзүүлэлтээр нэгтгэж үзэхэд үнэлгээний дундаж 19.6 хувьтай гарсан нь орон нутгийн төсвийн төслийн ил тод байдал маш хангалтгүй байгааг илтгэж байна (График 5).

График 5. Аймаг, нийслэлийн төсвийн төслийн ил тод байдал, хувиар



Төсвийн төслийн ил тод байдлыг эрэмбэлж үзвэл хамгийн өндөр нь Хөвсгөл аймаг 45 хувь, дараа нь Завхан аймаг 34 хувьтай байгаа бол 5 хувиас доош үнэлгээ авсан аймгууд ч байна.

Дүүргийн 2016 оны төсвийн төслийн ил тод байдал ч мөн хангалтгүй түвшинд буюу дундаж үнэлгээ нь 14.2 хувьтай гарчээ (График 6). Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн төсөл боловсруулах явцад, мөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэхдээ уг төслийг олон нийтэд огт танилцуулахгүй, ил тод болгохгүй байгаа бөгөөд зарим аймаг Сангийн яаманд хянуулсан төсвийн төслийн жагсаалтаа л Шилэн дансны цахим хуудсанд мэдээлжээ. Гэхдээ энэхүү мэдээллийг иргэд ойлгомжгүй, ач холбогдол багатай гэж үзэж байна. Түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас ИТХ болон аймаг, нийслэлийн ерөнхий аудиторт дараа жилийн төсвийн төслийг өргөн барьсан тухай мэдээлдэг ч өргөн барьсан төсвийн төслийг бүрэн хэмжээгээр ил тод болгохгүй байх нь элбэг байгаа ажээ.

График 6. Дүүргийн төсвийн төслийн ил тод байдал, хувиар



Төсвийн төслийг Архангай, Говьсүмбэр, Завхан, Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймгууд, Багахангай, Баянгол, Сүхбаатар, Налайх, Сонгинохайрхан дүүргүүд 2015 оны 10 дугаар сараас 12 дугаар сард хугацаа хоцроон зарим нь бүрэн, зарим нь бүрэн бус байдлаар нийтэлсэн байлаа.

Орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгааг гүйцэтгэх явцад аймаг, нийслэлийн Засаг дарга 2016 оны төсвийн төслөө аймаг, нийслэлийн ерөнхий аудиторт 11 дүгээр сарын 10-ны дотор өргөн барих үйл явц болон өргөн барьсан төсвийн төсөл нь нээлттэй биш байгаа нь харагдав. Хуульд заасан дээрх хугацаанд төсвийн төсөлдөө аудитын

дүгнэлт гаргуулахаар хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгох үйл явц хэрэгжихгүй байгаа нь судлаачид хүсэлт тавьж олж авсан нотлох баримтыг цаасаар ирүүлснээр нотлогдож байгаа юм.


Засаг дарга нар аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны төсвийн төслийг ИТХ-д өргөн барихдаа нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлж, олон нийтэд танилцуулаагүй ажээ. Харин Архангай, Дорноговь, Хөвсгөл аймгууд, Улаанбаатар хот, Багануур, Багахангай, Хан-Уул дүүргүүд төсвийн төслийг өргөн барьсан тухай л хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон орон нутгийн цахим хуудсандаа мэдээлсэн байна.

Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн төслийн баримт бичиг, түүнийг боловсруулах, хэлэлцэх үйл явцын ил тод, нээлттэй байдал хангагдахгүй байгаа нь орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох мэргэжилтнүүд Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, эдгээрт нийцүүлэн гаргасан тогтоол, журмын заалт, шаардлагыг бүрэн ойлгож, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахгүй байгаатай холбоотой юм.

ИТХ-ын хуралдааны ил тод байдал

Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийг хэлэлцэн баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдлын үнэлгээг (i) ИТХ-ын хуралдааны ил тод байдал, (ii) төсөв баталсан ИТХ-ын хуралдааны баримт бичгийн ил тод байдлын үнэлгээний дундажтай харьцуулан аймаг, нийслэлээр гаргав (График 7).

График 7. Аймаг, нийслэлийн 2016 оны төсөв хэлэлцэн баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдал, хувиар



Аймаг, нийслэлийн төсөв хэлэлцэн баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдлаар Хөвсгөл аймаг хамгийн дээд үнэлгээ (91) авч, Архангай аймаг, Улаанбаатар хот тус бүр 63 хувь, Увс аймаг 60 хувьтай гарчээ. Аймаг, нийслэлийн дундаж үзүүлэлт 47.1 хувь байгаа бөгөөд Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Орхон, Өмнөговь аймгууд дунджаас ч доогуур үнэлгээ авч байна.

Нийслэлийн дүүргүүдийн төсөв хэлэлцэн батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал аймаг, нийслэлийн дундаж түвшинд ч хүрэхгүй байлаа. Хэдийгээр Багануур, Баянгол, Баянзүрх дүүргүүд бусад дүүрэгтэй харьцуулахад бага зэрэг дээгүүр үнэлгээтэй гарч байгаа боловч дүүргүүдийн дундаж үнэлгээ нь 25.6 хувь буюу аймаг, нийслэлийн дунджаас даруй 21.5 хувиар бага байгаа юм. Гэтэл Багахангай, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргүүдийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал нь дүүргийн дундаж үнэлгээнээс 1.7–3.2 дахин доогуур байна.


Дүүргүүд төсвөө хэлэлцэн баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдлын нийт үнэлгээг График 8-д нэгтгэн харуулав.

График 8. 2016 оны төсвөө хэлэлцэн баталсан дүүргүүдийн ИТХ-ын хуралдааны ил тод байдал, хувиар



Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төсөл хэлэлцэж, баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдлыг харьцуулж үзэхэд Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудын болон нийслэлийн иргэд, иргэний нийгэм, төрийн бус байгууллагын төлөөлөл ИТХ-ын хуралдаанд оролцсон байв. Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдааны ил тод байдлын үнэлгээг нэгтгэн дүгнэж үзэхэд дундаж нь 26.9 хувь болж 2013 оныхоос 18.8 хувиар буурсан байв (График 9).


График 9. Аймаг, нийслэлийн төсвийн төсөл хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдлын үнэлгээний нэгтгэсэн дүн хувиар, 2013, 2016 оны харьцуулалт



Төсөв хэлэлцэн батлах хуралдаанд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн сэтгүүлчдийг оролцуулан сурвалжлуулах боломжийг Сүхбаатар, Төв, Хөвсгөл, Ховд аймгууд, Нийслэлийн ИТХ-аас олгожээ. Гэсэн хэдий ч төсөв хэлэлцэн батлах үйл явцын нээлттэй байдал аймаг, нийслэлийн дунджаар 2013 онд 68.0 хувьтай байсан бол 2016 онд 14 хувиар буурчээ. Зарим аймаг болон нийслэлийн төсөв хэлэлцсэн ИТХ-ын хуралдааныг радио, телевизээр шууд дамжуулсан нотлох баримтыг орон нутгийн судлаачид ирүүлсэн хэдий ч энэ үзүүлэлт өмнөх судалгааны дүнгээс буурсныг дээрх графикаас харж болно.


Дүүргүүдийн төсөв хэлэлцэн баталсан ИТХ-ын хуралдааны ил тод, нээлттэй байдал аймаг, нийслэлийнхээс ч доор байгаа юм. Тухайлбал, дүүргийн төсөв батлах ИТХ-ын хуралдаанд иргэд, иргэний нийгэм, ТББ-ын төлөөллийг оролцуулсан байдал нь аймаг, нийслэлийнхээс даруй 50 хувиар бага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сэтгүүлчдийг алдаг оног оролцуулж сурвалжлуулсан боловч радио, телевизээр бараг шууд дамжуулалгүй өнгөрсөн байна (График 10).

График 10. Дүүргийн 2016 оны төсвийн төсөл хэлэлцэж, баталсан ИТХ-ын хуралдааны ил тод байдал, хувиар



Аймаг, нийслэлийн төсөв хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны баримт бичгүүдийн нээлттэй байдал 2013 оныхтой харьцуулахад үзүүлэлт тус бүрээр 4-23 хувиар дээшилжээ. 2016 оны судалгаагаар хуралдааны тогтоол шийдвэр, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө харьцангуй нээлттэй байгаа бол хуралдааны тэмдэглэл, хуралдаанд тараасан илтгэл, танилцуулга олон нийтэд бүрэн ил болохгүй байгаа нь харагдав (График 11).

График 11. Аймаг, нийслэлийн төсөв хэлэлцэж, баталсан хуралдааны баримт бичгийн ил тод байдал, хувиар (2013, 2016 оны харьцуулалт)



Энэ удаагийн судалгааны дүнгээс харахад орон нутгийн төсөв хэлэлцэн батлах ИТХ-ын хуралдааны нээлттэй байдал ерөнхийдөө өмнөхөөсөө буурсан боловч хуралдааны баримт бичгийн ил тод байдал сайжирсан байгаа нь анзаарагдав. Аймаг, нийслэлийн төсөв хэлэлцсэн ИТХ-ын хуралдааны тогтоол, шийдвэр хугацаа хоцорсон ч олон нийтэд нээлттэй (66.7 хувь) тавигддаг болсон бол хэлэлцэх асуудлын төлөвлөгөө,

тэмдэглэл, илтгэл танилцуулга албан хэрэгцээний зориулалтаар л тараагддаг хэвээр байна.

Дүүргүүдийн хувьд 2016 оны төсөв хэлэлцэн батлах ИТХ-ын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний нээлттэй байдал дунджаар 33.3 хувьтай байна. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Хан-Уул дүүрэг цахим хуудсандаа байрлуулсан бол харин Сүхбаатар, Баянгол дүүргүүд хүсэлт тавьсны дагуу орон нутгийн судлаачдад өгсөн байна. Дүүргүүд хуралдаанд хэлэлцүүлсэн илтгэл, танилцуулгаа ил тод болгох нь нэн хангалтгүй (13 хувь) буюу зөвхөн ИТХ-ын тэргүүлэгчид, төлөөлөгчдөд тараадаг ба хуралдааны тэмдэглэл буюу протоколыг албан хэрэгцээнд л зориулан ашигладаг (24.1 хувь) байна. Харин орон нутгийн төсөв баталсан тогтоол, шийдвэрийг дүүргүүд цахим хуудсандаа хугацаа хоцроосон ч бүрэн эхээр нь байршуулсан байлаа (График 12).

График 12. Дүүргийн 2016 оны төсөв хэлэлцэж, баталсан хуралдааны баримт бичгийн ил тод байдал, хувиар




Шилэн дансны тухай хууль батлагдан хэрэгжиж байгаатай холбоотойгоор ИТХ-аар төсөв баталсан тогтоолыг иргэд Шилэн дансны цахим хуудсанд болон орон нутгийн албан ёсны цахим хуудаснаас бүрэн эхээр нь авах боломжтой байгаа ч холбогдох бусад баримт бичгийг нээлттэй эх сурвалжаас иргэн бүр олж үзэх боломж хомс байдаг нь үнэлгээний явцад харагдсан болно.

Батлагдсан төсвийн ил тод байдал

2016 оны батлагдсан төсвийн ил тод байдлын үнэлгээг нэгтгэн гаргавал аймаг, нийслэлийн түвшинд 60.4, дүүргийн түвшинд 51.4 хувьтай гарлаа. Аймаг, нийслэл, дүүргүүдийн батлагдсан төсвийн нээлттэй

байдлыг үнэлэх зургаан шалгуураас (i) батлагдсан төсвийг бүрэн эхээр нь олон нийтэд ил болгох, (ii) ОНХС-ийн төлөвлөгөөг ил болгох хоёр үзүүлэлт хамгийн өндөр хувьтай байв (График 13). Хуулийн дагуу аймаг, нийслэл, дүүргийн түвшинд орон нутгийн төсвийг батлагдсан бүрэн эхээр нь буюу аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын хуралдааны төсөв батлах тухай тогтоол, төсвийн орлогын нэр төрөл, дүн, төсвийн зарлага, шилжүүлгийн хэмжээ, хөрөнгө оруулалтын жагсаалт, ОНХС-гаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан маягтуудаар 2016 оны 1 дүгээр сарын 10-ны дотор олон нийтэд мэдээлсэн байдал, 2016 оны батлагдсан төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор ил тод болгохдоо аймаг, нийслэл, дүүргийн ОНХС-ийн 2016 оны төлөвлөгөөг ШДЦХТМАНСТЖ-ын 11-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал гэсэн 2 үзүүлэлт бусдаас харьцангуй өндөр буюу 60-аас дээш оноотой үнэлэгджээ (График 13).

График 13. Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны батлагдсан төсвийн ил тод байдлын үнэлгээ, хувиар



Аймаг, нийслэлийн түвшинд батлагдсан төсвийн бусад үзүүлэлт 50-иас дээш хувьтай үнэлэгдсэн хэдий ч Засаг дарга нар 2016 оны сар, улирлын хуваариа батлан Сангийн яаманд хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгож танилцуулахгүй байгаа нь харагдав. Энэ үзүүлэлтийн үнэлгээний дүн харьцангуй доогуур буюу 27.6 хувьтай гарчээ.

Орон нутгийн 2016 оны батлагдсан төсвийг 2016 оны 1 дүгээр сарын 10-ны дотор олон нийтэд иж бүрэн ил тод болгож, мэдээлэх ажлыг Хөвсгөл, Сэлэнгэ, Увс, Өмнөговь, Говь-Алтай, Булган, Баянхонгор аймгууд, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол дүүргүүд хуулийн дагуу гүйцэтгэжээ. Харин Сүхбаатар, Завхан аймгууд бүх маягтаар, хугацаанд нь олон нийтэд бүрэн ил тод мэдээлээгүй байна.


Иргэний төсөв

Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ, Засаг даргын зүгээс орон нутгийн төсвийн талаар иргэдэд зориулан хялбаршуулан бэлтгэдэг “иргэний төсөв”-ийг огт гаргадаггүй хэвээр байна. Шилэн дансны болон Төсвийн тухай хуулиудын дагуу төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн удирдлага болон төсвийн байгууллагуудын зүгээс иргэний төсөв бэлтгэх шаардлага, хэлбэрийг нарийвчлан тодорхойлж, “иргэний төсөв” бэлтгэх аргачлал, заавар, програм хангамж боловсруулж, хэрэглэх шаардлагатай нь судалгааны явцад харагдсан болно.

Төсвийн тодотголын ил тод байдал

2015 оны сүүлийн хагас жил, 2016 оны эхний 5 сарын байдлаар бүх аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тодотгол хийгджээ. Төсвийн тодотголын төслийг ИТХ-аар хэлэлцэн батлахдаа Баянхонгор, Говь-Алтай, Увс аймгууд, Улаанбаатар хот олон нийтэд тодотгол баталсан тухай мэдээлж, Шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцорсон ч нийтэлсэн бол төсвийн тодотгол хэлэлцсэн ИТХ-ын хуралдааныг Увс, Говь-Алтай аймгууд нээлттэй буюу орон нутгийн телевизээр шууд дамжуулсан байна. Харин Дархан-Уул, Дундговь, Баян-Өлгий, Архангай, Орхон аймгуудын төсвийн тодотголын ил тод байдал нэн хангалтгүй байгааг График 14-өөс харна уу.


График 14. Аймаг, нийслэлийн төсвийн тодотголын ил тод байдлын үнэлгээ, хувиар



Орон нутгийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тодотгосон төсвийн тухай мэдээллийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, стандартыг тогтоох журам (ШДЦХТМАНСТЖ)-ын 1, 20-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байх ёстой боловч ихэнх аймаг шаардлагатай мэдээлээ хугацаа хоцроон нийтэлжээ. Төсвийн тодотголын ил тод байдлыг аймаг, нийслэлийн дунджаар авч үзвэл өмнөх судалгааны дүнгээс 5.1 хувиар буурч 36.4 хувь болсныг төсвийн захирагч нар анхаарах шаардлагатай.

Дүүргүүдийн төсөвт 2015, 2016 онд хийсэн төсвийн тодотголын ил тод байдал аймаг, нийслэлийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад 2 дахин доогуур түвшинд байна. Баянзүрх, Багануур, Сүхбаатар дүүргүүдийн үнэлгээ 20-иос дээш хувьтай байгаа бол Чингэлтэй, Налайх, Хан-Уул дүүргүүд төсвийн тодотголын мэдээллийг ил тод болгох үүргээ маш хангалтгүй биелүүлжээ (График 15).


График 15. Дүүргийн төсвийн тодотголын ил тод байдлын үнэлгээ, хувиар



Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал

Аймаг, нийслэлийн 2015, 2016 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал тавигдаж буй шаардлагын 50 гаруй хувийг хангаж байна (График 16). Энэ нь аймаг, нийслэлийн 2015 оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан (61.7 хувь), 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (81.8 хувь), 2015 оны 6 дугаар сараас 12 дугаар сар, 2016 оны 1 дүгээр сараас 5 дугаар сарын худалдан авалтын явц, үр дүнгийн ил тод байдал (48 хувь) өмнөх үнэлгээний дүнгээс ахисантай холбоотой.

График 16. Аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал, хувиар



Аймаг, нийслэлийн Засаг дарга 2015 оны худалдан авах ажиллагааны жилийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ ШДЦХТМАНСТЖ-ын 22-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсаар олон нийтэд танилцуулж, ил тод болгох үүргээ Ховд, Баян-Өлгий, Хөвсгөл, Завхан, Төв аймгууд огт биелүүлээгүй байна. Харин бусад аймаг болон нийслэл хотын хувьд хугацаа хоцроосон ч Шилэн дансны цахим хуудсанд нийтэлжээ.

Худалдан авах ажиллагааны 2016 оны жилийн төлөвлөгөөг Говьсүмбэр, Дорнод, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгууд, Улаанбаатар хот 2016 оны 1 дүгээр сарын 10-ны дотор буюу хугацаанд нь ШДЦХТМАНСТЖ-ын 21-р хавсралтын дагуу боловсруулж Шилэн дансны цахим хуудсанд иж бүрэн мэдээлж, олон нийтэд ил тод болгосон байна. Эдгээрээс бусад аймаг хугацаа хоцорсон ч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар мэдээлсэн тул энэ үзүүлэлтийн дундаж үнэлгээ 81.8 хувьтай буюу харьцангуй сайн гарчээ (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Аймаг, нийслэлийн 2015 оны 6–12 дугаар сар, 2016 оны 1–5 дугаар сарын худалдан авалтын явц, үр дүнгийн ил тод байдал, хувиар

Үзүүлэлт	Үнэлгээ (хувь)
Тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, тогтмол нийтэд мэдээлж, санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилсэн байдал	39
Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүрийн 8-ны дотор олон нийтэд танилцуулж, Шилэн дансны цахим хуудсанд байрлуулан ил тод болгосон байдал	53
Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл ТББ-ын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилсон иргэнийг оролцуулсан байдал	55
Тухайн ажил, үйлчилгээний гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг байрлуулсан байдал	14

Хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг Үнэлгээний хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор цахимаар мэдээлсэн байдал	41
Зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор мэдээлсэн байдал	51
Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар мэдээлж ил тод болгосон байдал	50
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор цахимаар мэдээлсэн байдал	56
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт цахимаар ил тод болгосон байдал	72

Аймаг, нийслэлийн Засаг дарга нар өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх сар бүрийн тайланг дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал хангалтгүй байгаа нь энэ үзүүлэлтийн үнэлгээ 53 хувьтай байгаагаас харагдаж байна.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2015, 2016 онд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хөндлөнгийн хоёроос доошгүй төлөөллийг оролцуулсан байдлын үнэлгээ 55 хувьд хүрчээ. Булган, Өмнөговь зэрэг аймгууд хуульд тусгагдсан дээрх төлөөллийг оролцуулан үнэлгээний хороо байгуулан ажиллуулж, үнэлгээний хороо байгуулсан шийдвэрийг олон нийтэд хууль, журмын дагуу мэдээлж ажилладаг нь баримтаар нотлогдож байгаа юм.

Дүүргийн Засаг даргын дэргэд 2013 оноос эхлэн Худалдан авах ажиллагааны алба байгуулагдан ажиллаж байгаа, Шилэн дансны тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, явц үр дүнгийн мэдээллийг тухай бүр мэдээлэх хууль эрх зүйн зохицуулалт бий болж, хэрэгжиж байгаа хэдий ч дүүргүүдийн түвшинд хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал хангалтгүй буюу дунджаар 35 хувьтай байна. Нийслэлийн Налайх, Баянзүрх, Чингэлтэй,

Сонгинохайрхан дүүргүүд бусад дүүргээс бага зэрэг өндөр үнэлгээтэй байгаа ч иргэдэд илүү ойр ажилладаг дүүргийн түвшинд хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлага байгааг судалгааны дүн харуулаа (График 17).

График 17. Дүүргийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал, хувиар




Төсвийн гүйцэтгэлийн ил тод байдал

Аймаг, нийслэл, дүүргийн 2014, 2015, 2016 оны төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлыг 2015–2016 оны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, 2015 оны хагас, бүтэн жилийн тайлан, 2014 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн ил тод байдлыг харгалзан үнэлж үзвэл аймаг, нийслэлийн дундаж 65.6 хувьтай буюу өмнөхөөс 10 хувиар өссөн байна. Харин дүүргүүдийн төсвийн гүйцэтгэлийн ил тод байдал дунджаар 67.6 хувьтай гарсан байгаа нь аймаг, нийслэл, дүүргийн төсвийн баримт бичгүүд дотроос ил тод байдлаараа хамгийн өндөр үнэлгээ авсан үзүүлэлт болсон байна.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлаараа Сүхбаатар, Хөвсгөл, Баянхонгор, Сэлэнгэ, Булган, Дорноговь, Өмнөговь аймгууд бусад аймаг, нийслэл хотыг тэргүүлж байгаа бол Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Дорноговь аймгуудын төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлын үнэлгээ харьцангуй доогуур түвшинд байна (График 18).

График 18. Аймаг, нийслэлийн төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлын харьцуулалт, хувиар



Аймаг, нийслэлийн төсвийн гүйцэтгэлийн сар, улирал, хагас, бүтэн жилийн мэдээг Булган, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл аймгуудын төсвийн ерөнхийлөн захирагч нар сар бүрийн 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлж, сар бүрийн 8-ны дотор Шилэн дансны болон орон нутгийн цахим хуудсанд иж бүрэн мэдээлж байгаа нь сайшаалтай. Харин бусад аймаг төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хугацаа хоцроож, эсвэл орон нутгийн хэмжээнд бүрэн бус нэгтгэн гаргажээ. Аймаг, нийслэлийн түвшинд төсвийн гүйцэтгэлийн сар, улирал, хагас, бүтэн жилийн мэдээг олон нийтэд мэдээлдэг тул энэ үзүүлэлтийн үнэлгээ харьцангуй өндөр буюу 63.1 хувьтай гарчээ.

Аймаг, нийслэлийн ТЕЗ нар 2015 оны төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайланг 2015 оны 8 дугаар сарын 15-ны дотор ил тод болгох ёстой. Гэтэл аймаг, нийслэл уг тайланг хугацаа хоцроож Шилэн дансны цахим хуудсанд нийтэлсэн байна. Булган, Баянхонгор, Говь-Алтай, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Хөвсгөл, Хэнтий аймгууд дээрх тайланг цахим хуудсанд иж бүрнээр нийтэлсэн ч хугацаа хоцроожээ.

Харин 2015 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор орон нутгийн цахим хуудас болон Шилэн дансны цахим хуудсанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал нь төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлыг илтгэх бусад үзүүлэлтийн дунджаас дээгүүр үнэлэгджээ (81.8 хувь). Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь,

Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгууд, Улаанбаатар хот 2015 оны төсвийн гүйцэтгэлийг Шилэн дансны болон орон нутгийн цахим хуудсуудад хугацаанд нь нийтэлжээ. Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Орхон, Өвөрхангай, Төв, Увс, Ховд аймгууд өмнөх оны буюу 2015 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хугацаа хоцроож нийтэд ил тод болгосон бол Баян-Өлгий, Завхан аймгуудын Шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбарт энэ төрлийн мэдээлэл гаргасан гэх баримт нотолгоо олдоогүй юм.

Аймаг, нийслэлийн 2015 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн аудитын газраас аудит хийсэн тайлангийн ил тод байдал судалгаанд хамрагдсан төсвийн баримт бичгүүдээс хамгийн өндөр буюу 83.3 хувьтай үнэлэгдэж, өмнөх судалгааны дүнгээс 14.7 хувиар өсжээ. Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудын хувьд энэхүү тайланг хугацаанд нь олон нийтэд мэдээлсэн бол Баян-Өлгийгөөс бусад аймаг хугацаа хоцроосон ч тайлангаа нийтэлсэн байна. Үүний зэрэгцээ аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар нийтлэх үүрэгтэй боловч Баян-Өлгий, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий аймгууд болон Нийслэл хот энэ тайланг олон нийтэд мэдээлээгүй. Түүнчлэн бусад аймаг Шилэн дансны болон орон нутгийн цахим хуудсандаа хугацаа хоцроож нийтэлжээ.

Дүүргийн түвшинд төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлын дундаж үнэлгээ төсвийн бусад баримт бичгийн үнэлгээнээс өндөр буюу 67.6 хувьтай гарлаа (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Дүүргийн төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлын үнэлгээний харьцуулалт, хувиар

Үзүүлэлт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	Дундаж
2015 оны 6–12 дугаар сар, 2016 оны 1–5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сар, улирал, хагас, бүтэн жилийн мэдээ (Сар бүрийн 8-ны дотор)	50	53	72	53	61	64	58	58	67	59.6
2015 оны төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайлан (2015 оны 8 дугаар сарын 15-ны дотор)	0	75	5	75	75	75	75	75	0	58.3
2015 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан (2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор)	75	100	100	100	100	75	100	100	75	91.7
Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор)	100	100	100	100	100	75	75	100	100	94.4
Дүүргийн Засаг дарга 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор)	0	75	75	75	75	75	75	0	0	50.0

Дүүргүүдийн төсвийн гүйцэтгэлийн сар, улирал, хагас, бүтэн жилийн мэдээ, 2015 оны төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайлан, Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн нээлттэй, ил тод байдал дүүргийн дунджаар 60 хувиас бага байгааг дээрх хүснэгтээс харж болно. Харин нийслэлийн дүүргүүд 2015 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн эцсийн тайлан, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг үндсэндээ хугацаанд нь, иж бүрнээр нь Шилэн дансны болон дүүргийн албан ёсны цахим хуудсанд мэдээлж, иргэд олон нийтэд нээлттэй болгожээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн ил тод байдал

ОНХС-ийн ил тод байдал аймаг, нийслэлийн нэгдсэн үнэлгээгээр 21.7 хувь байгаа нь 2013 оны 38.5-аас 16.8 хувиар буурсан үзүүлэлт

Дүүргүүдийн ОНХС-ийн мэдээлэл үндсэндээ хаалттай байна.

болж байна. Харин дүүргүүдийн дундаж үнэлгээ 7.1 хувьтай гарсан нь Төсвийн болон Шилэн дансны тухай хуулиуд хэрэгжиж, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, төсвийн үйл явцад иргэдийг оролцуулах нөхцөл бүрдсэн энэ үед маш хангалтгүй үзүүлэлт юм.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нар тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, 2015 оны 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн санал авах ёстой атал Дархан-Уул, Дундговь аймаг хугацаа хоцроожээ. Харин Говьсүмбэр аймгийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан нэгдсэн жагсаалт гарган тухайн шатны ИТХ-д 2016 оны төсвийн төслийн хамт өргөн мэдүүлжээ. Гэхдээ өргөн мэдүүлсэн төслөө иргэд, олон нийтэд хугацаа хоцроож танилцуулсан бол бусад бүх аймаг, нийслэл, дүүргийн ОНХС-гийн төлөвлөлтийн мэдээлэл олон нийтэд ил болоогүй байна.

Хүснэгт 8. Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны ОНХС-ийн ил тод байдал, хувиар

Үзүүлэлт	Аймаг, нийслэлийн дундаж	Дүүргүүдийн дундаж
ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар иргэдээс санал авсан, урьдчилсан жагсаалт гаргаж хэлэлцүүлсэн болон түүнийг шийдвэрлэсэн үйл явц, түүний ил тод, нээлттэй байдал	17.0	10.3
Сум, дүүргийн Засаг дарга баг, хорооны ИНХ-аас баталгаажсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүйгээс саналын жагсаалтыг тусад нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэхдээ ил тод болгосон байдал	11.4	0.0
ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаар цаг хугацаанд нь иж бүрэн, ил тод мэдээлсэн байдал	35.6	13.9

Дээрх хүснэгтээс харахад Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу аймаг, нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар иргэдээс санал авах үйл явцын ил тод, нээлттэй байдал хангагдахгүй байна. Энэ нь аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаар шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах эхний алхмууд хийгдэж байгаа хэдий ч санал авах, хэлэлцүүлэг хийх үйл явцад иргэд оролцоо байхгүй, энэ талаар мэдээлэл багатай байгааг харуулна.

Түүнчлэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар ИТХ-д төсвийн төслийг өргөн барихдаа ОНХС-гаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаа иргэд, олон нийтэд танилцуулах үйл явц хангалттай ил тод болохгүй байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн ил тод байдал

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаарх 2015, 2016 оны мэдээллийг Засаг даргын Зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулахдаа олон нийтэд ил тод болгосон байх хуулийн заалтыг бүхий л түвшинд хангалтгүй хэрэгжүүлж байна. Энэ байдал нь аймаг, нийслэлийн түвшинд 22.3 хувь, дүүргүүдийн түвшинд 13.9 хувьтай үнэлэгдлээ.

Харин Сэлэнгэ аймаг орон нутгийн албан ёсны цахим хуудсандаа Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг 2015 онд сар бүр мэдээлсэн, 2016 оны зарцуулалтыг мэдээллийн самбартаа байршуулсан бол Говьсүмбэр аймгийн Засаг даргын нөөц сангийн 2016 оны хагас жил хүртэлх мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбарт улирал бүр байршуулан Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулсны зэрэгцээ ТЕЗ-ийн санхүүгийн тайлангаас Засаг даргын нөөц хөрөнгийн тайланг салган тусгайлан гаргаж, ил тод байршуулсан байсныг дурдах нь зүйтэй.

Орон нутгийн судлаачид Говь-Алтай, Завхан, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн Засаг дарга нарын нөөц хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг хүсэлт тавьсны үндсэн дээр холбогдох албан тушаалтнуудаас авсан болно.

Орон нутгийн тусгай сангуудын ил тод байдал

Аймаг, нийслэл, дүүргийн түвшинд 2015 оны 6 дугаар сараас 12 дугаар сар, 2016 оны 1 дүгээр сараас 5 дугаар сард Аймаг, нийслэл, дүүрэг хөгжүүлэх сан, Замын сан, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан зэрэг тусгай сангуудын орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, үлдэгдлийн сар (улирал, хагас болон бүтэн жил)-ын мэдээг дараа сарын 8-ны дотор ШДЦХТМАНСТЖ-ын 2-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсанд байрлуулах ёстой. Уг үйл ажиллагааг олон нийтэд хэрхэн ил тод болгосон байдлыг үнэлж үзэхэд аймаг, нийслэлийн түвшинд 58.7 хувьтай, дүүргүүдийн түвшинд 44.4 хувьтай гарлаа. Архангай, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд, Баянгол, Налайх, Хан-Уул дүүргүүд орон нутгийн тусгай сангуудын мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроосон ч нийтэлжээ. Харин Дундговь аймаг, Багахангай дүүрэг ямар ч мэдээлэл нийтлээгүй бол бусад аймаг, нийслэл, дүүрэг ямар нэг хэмжээний мэдээлэл Шилэн дансны болон болон орон нутгийн цахим хуудсандаа байршуулжээ.

Архангай аймаг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн талаарх мэдээллийг “Архангайн амьдрал” сонинд нийтэлсэн бол Говьсүмбэр аймаг маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулсан байгаа боловч 2015, 2016 онуудад тусгай сан гэж тодорхойлсон мэдээлэл байхгүй байв. Гэхдээ Шилэн дансны цахим хуудсанд 2015 оны Авто замын сангийн үйл ажиллагаанд Аудит хийгдсэн санхүүгийн тайланг байршуулсан байлаа.

Ихэнх аймаг Шилэн дансны цахим хуудсанд орон нутгийн тусгай сангийн мэдээллийг хугацаанд нь, эсвэл хугацаа хоцроон ногоон, шар тэмдэглэгээтэй оруулсан байгаа хэдий ч “гүйлгээ хийгдээгүй” гэсэн тайлбарыг сар бүр тавьсан, эсвэл ерөнхий мэдээлэл, зарим тохиолдолд хоосон хүснэгт нийтэлсэн нь элбэг байжээ.

Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал

Төсвийн тухай хуулийн 25.8 дахь заалтын дагуу “Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эсхүл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ”,

Сангийн сайдын 2010 оны 45-р тушаалаар батлагдсан “Хандив тусламжийг бүртгэх журам”-ын 2.4-т зааснаар “хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгө, түүний зарцуулалтын талаар олон нийтэд зохих журмын дагуу мэдээлэх” шаардлагыг тодорхойлсон билээ.

Түүнчлэн “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 3.2.7 дахь заалтын дагуу төсвийн байгууллага “хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор уг журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар нийтэд мэдээлэх үүрэгтэй. Иймээс энэхүү судалгааны хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Шилэн дансны цахим хуудас дахь хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг ил тод болгосон байдлыг үнэлсэн болно. Аймаг, нийслэлийн түвшинд хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал 45.6 хувьтай, дүүргийн түвшинд дунджаар 63.9 хувьтай үнэлэгджээ.

Дархан-Уул, Завхан, Сүхбаатар, Хөвсгөл, Өвөрхангай, Увс аймгууд, Нийслэл хот, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдийн ЗДТГ 2015 оны хандив, тусламжийн хөрөнгийн хагас, бүтэн жилийн тайлангаа Шилэн дансны цахим хуудсандаа хугацаа хоцроож нийтэлжээ. Харин Баян-Өлгий, Булган, Дундговь, Өмнөговь, Хэнтий аймгийн ЗДТГ хандив, тусламж авсан эсэх талаар ямар ч мэдээлэл нийтлээгүй байв. Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын талаарх мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь, эсвэл хугацаа хоцроож нийтэлсэн аймаг, дүүргүүд ихэвчлэн “хандив, тусламж аваагүй, гүйлгээ гараагүй, байхгүй” гэсэн мэдээлэл оруулсан байлаа.

ГУРАВ. Дүгнэлт, бодлогын зөвлөмж

Монгол Улсын төсвийн хувьд 2016 он Төсвийн болон Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад нийцүүлэн Засгийн газар, Сангийн сайдын шийдвэрээр холбогдох журмууд батлагдан орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах эрх зүйн зохицуулалт бүрдэж, иж бүрэн хэрэгжсэн онцлог үе байлаа. 2016 онд аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ил тод, нээлттэй байдал 2013 оныхтой харьцуулахад 3 хувиар дээшилсэн хэдий ч дундаж үнэлгээ 39 хувьтай байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

Орон нутгийн төсвийн ил тод байдал хангалтгүй байгаагийн шалтгаан нь:

- хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих ИТХ-ын болон ТЕЗ-ийн дотоод хяналт сул;
- төсвийн үйл явцын болон баримт бичгийн ил тод байдлыг хангаагүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Шилэн дансны тухай хуульд тусган хуульчилсан ч хуулийн хэрэгжилтийг холбогдох этгээдүүд тухай бүр хянаж, үнэлэхгүй байгаагаас хариуцлагын механизм үйлчлэхгүй байгаа;
- мэдээллийг ил тод болгох үүрэг бүхий албан тушаалтнууд гаргасан мэдээллээ цахим хуудсанд нийтлэхэд цаг хугацаа алддагаас гадна ихээхэн хүч хөдөлмөр зарцуулдагтай холбоотой гэж үзэж байна.

Түүнчлэн үйлчилж буй хууль тогтоомж, журам заавар, аргачлалыг холбогдох албан тушаалтнууд үзэж судлаагүй, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудаас боловсруулж гаргасан загвар, стандартыг хэрэгжүүлэх

чиглэлээр сургалт, сурталчилгаа бараг хийгдээгүй, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн загвар нь төсвийн захирагчдын гаргасан мэдээ, тайлангийн маягаас зөрүүтэй байдаг нь ч нөлөөлсөн байх талтай.

Энэ удаагийн орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээг 12 багц үзүүлэлтэд тулгуурлан хийлээ. Орон нутгийн төсвийн ил тод байдлын 2013 оны судалгааны дүнтэй харьцуулахад төсвийн ил тод байдлыг нутгийн удирдлагын зүгээс гаргаж буй эрх зүйн баримт бичигт тусган зохицуулсан байдлын үнэлгээ 1.3 хувиар буурсан нь өмнөх судалгааны үзүүлэлтийг Төсвийн болон Шилэн дансны тухай хуулиудад нийцүүлэн өөрчилсөнтэй холбоотой гэж үзэж байна. Харин судалгаанд хамруулсан үйл явц, баримт бичгүүдээс 7 багц үзүүлэлтийн үнэлгээ өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг сайжирсан байна. Тухайлбал, төсвийн төсөл, төсөв хэлэлцэн баталсан ИТХ-ын хуралдаан, батлагдсан төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, орон нутгийн тусгай сангууд, хандив тусламжийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал 1.1–28.8 хувиар дээшилжээ. Харин нутгийн удирдлагын зүгээс төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр гаргасан эрх зүйн баримт бичиг, иргэний төсөв, төсвийн тодотгол, орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц хөрөнгийн ил тод байдал 1.1–16.8 хувиар буурсан байна.

2016 онд дүүргүүдийн төсвийн ил тод байдлыг анх удаа үнэллээ. Дүүргүүдийн дундаж үзүүлэлт 31.1 хувьтай гарсан нь төсвийн ил тод байдал дүүргийн түвшинд тун хангалтгүй байгааг илтгэнэ. Дүүргүүдийн нэгдсэн үнэлгээгээр төсвийн гүйцэтгэлийн болон хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал 60-аас дээш хувийн үнэлгээтэй байгаа бол иргэдэд нэн чухал төсвийн мэдээлэл болох иргэний төсөв, ОНХС, төсвийн төсөл, төсвийн тодотгол, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал маш тааруу буюу 20-иос доош хувьтай үнэлэгджээ. Орон нутгийн судлаачдын цуглуулсан мэдээлэл, баримт нотолгоо, Шилэн дансны цахим хуудсанд нийтэлсэн мэдээлэл, хараат бус багийн үнэлгээнд тулгуурлан дунджаар үнэлэхэд орон нутгийн төсвийн буюу аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ил тод байдал хангалтгүй түвшинд байгаа нь харагдлаа.

Судалгааны дүнд тулгуурлан цаашид аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлээр дараах бодлогын Зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн ил тод байдлыг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг төсвийн захирагчид ханган ажиллах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулах;
- Орон нутгийн түвшний эрх зүйн баримт бичигт төсвийн ил тод байдлыг тодорхой тусган зохицуулахын зэрэгцээ Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Иргэдийн нийтийн хурлаас тавих хяналтын журмыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлан мөрдөж ажиллах;
- Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах чиг үүргийг аймаг, нийслэл болон сум, дүүрэг, байгууллагын удирдлагын түвшин бүрээр зааглан тодорхой болгох;
- Шилэн дансны цахим хуудсанд нийтлэх мэдээлэл болон орон нутаг, байгууллагын төсөв захирагчдын гаргадаг мэдээллийн уялдаа, нийцлийг хангах (төсвийн баримт бичиг боловсруулж, тайлан мэдээ гаргаж буй ажилтанд төвөггүй, мэдээлэл ашиглах хэрэглэгчдэд энгийн хялбар байх зарчмыг баримтлах);
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ажлыг хянан шинжилж, үнэлэх шалгуур үзүүлэлтэд төсвийн ерөнхийлөн захирагч орон нутгийн төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж буй эсэх талаар үзүүлэлт оруулах;
- Орон нутгийн төсвийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар мэдээлэлтэй иргэд төсвийн үйл явцад бүтээлчээр оролцох буюу төсөв боловсруулах, хэлэлцэн батлах үе шатанд санал өгөх, төсвийн гүйцэтгэл, хэрэгжилтийн үе шатанд хяналт тавих замаар оролцох нөхцөлийг бүрдүүлэх;
- Орон нутгийн төсвийн үйл явцын болон ил тод байдлын цаглабар, түүнийг хэрхэн үр дүнтэй мөрдөж ажиллах талаар төсвийн захирагч нарт зориулсан ханын хуанли, ойлгомжтой гарын авлагыг энгийн хэлбэрээр бэлтгэж, тараах;
- Орон нутгийн төсвийн ил тод байдалд цахим хэлбэрээр хяналт тавих дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний албаны ажилтнуудад ашиглахад хялбар програм хангамжийг бий болгох нь зүйтэй.

Хавсралтууд

1. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээний нэгтгэл–2016
2. Дүүргийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээний нэгтгэл–2016
3. Орон нутаг тус бүрийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дүн /21 аймаг, нийслэл, 9 дүүрэг/
4. Орон нутгийн төсвийн баримт бичгүүд болон төсвийн үйл явцын нээлттэй, ил тод байдлыг үнэлэхэд ашиглах шалгуур үзүүлэлт, түүнд харгалзах оноо
5. Асуулга
6. Судалгааны багийн талаарх мэдээлэл

Хавсралт 1. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээний нэгтгэл – 2016

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Архангай	Баян-Өлгий	Булган	Баянхонгор	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Ховд	Хөвсгөл	Хэнтий	Улаанбаатар	Дунгаж	Авсан оноо
1	Орон нутгийн бодлогын баримт бичигт төсвийн ил тод байдлыг тусгасан эсэх (Тухайлбал, аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилт)	63	25	38	75	75	100	50	25	50	38	50	75	75	100	25	100	75	38	25	100	75	88	62	2.5
2	Аймаг, нийслэлийн ИТХ ба Тэргүүлэгчдийн хурлаас төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан тогтоол, шийдвэр	0	0	0	0	0	25	0	0	0	0	25	25	0	75	0	0	0	0	0	0	0	0	7	0.3
3	Аймаг, нийслэлийн Засаг даргын 2016 онд салбарын ТЭЗ нартай, Нийслэлийн Засаг даргаас дүүргийн Засаг дарга нартай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ	38	25	38	38	25	25	38	25	25	25	63	25	25	75	63	63	50	25	25	50	50	63	42	1.7
4	Аймаг, нийслэлийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	38	50	50	38	25	88	100	38	63	88	50	50	63	100	100	100	63	75	25	100	38	63	64	2.5
5	Аймаг, нийслэлийн Засаг дарга төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан захирамж, албан даалгавар	88	100	0	0	63	50	63	0	25	0	63	50	100	75	0	100	75	75	0	88	0	63	49	2.0

6	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга болон байгууллагын төсвийн шууд захирагч нар Засаг даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээ (ҮДГ) -нд тусгагдсан төсвийн ил тод байддалтай холбоотой заалт	63	25	38	50	38	63	63	63	63	25	63	63	63	75	75	75	75	75	75	50	25	63	38	63	56	2.2
7	Аймаг, нийслэл, АУУргийн ЗДТГ-ын даргын СТСХ-ийн даргатай байгуулсан ҮДГ-д тусгагдсан төсвийн ил тод байддалтай холбоотой заалт	25	25	0	50	38	63	63	25	38	25	63	75	75	75	75	75	75	75	75	50	25	63	75	63	48	1.9
8	Аймгийн ЗДТГ-ын дарга болон СТСХ-ийн даргын гаргасан төсвийн ил тод байддалтай холбогдох албан бичиг, үүрэг даалгавар	0	0	0	0	0	63	0	0	0	0	0	0	0	75	75	75	75	75	75	50	0	75	75	0	22	0.9
9	Аймаг, нийслэл, АУУргийн ИТХ болон иргэдээс төсвийн ил тод байдалд тавих хөндлөнгийн хяналтын журам, түүний хэрэгжилт	0	0	0	0	0	0	0	0	50	0	25	50	75	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	9	0.4
10	Аймаг, нийслэл, АУУргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас төсвийн ил тод байдалд тавих дотоод хяналтын журам, түүний хэрэгжилт	25	0	0	0	13	100	0	0	0	25	38	25	75	13	38	0	50	0	25	0	25	25	0	20	0.8	
Нэгдсэн үнэлгээ		34	25	16	25	28	49	44	14	25	25	41	39	51	70	50	63	49	41	13	56	38	40	38	1.5		
Авсан дундаж оноо		1.4	1.0	0.7	1.0	1.1	2.0	1.8	0.6	1.0	1.0	1.7	1.6	2.1	2.8	2.0	2.5	2.0	1.7	0.5	2.3	1.5	1.6	1.6	1.5		

Хавсралт 2. Дүүргийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдлын үнэлгээний нэгтгэл–2016

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Багануур	Багахангай	Баянгол	Баянзүрх	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	Хан-Уул	Чингэлтэй	Дундаж	Авсан оноо
1	Орон нутгийн бодлогын баримт бичигт төсвийн ил тод байдлыг тусгасан эсэх (Тухайлбал, дүүргийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилт)	50	100	100	75	75	75	63	25	100	74	2.9
2	Дүүргийн ИТХ ба Тэргүүлэгчдийн хурлаас төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан тогтоол, шийдвэр	0	0	0	0	50	0	0	0	0	6	0.2
3	Нийслэлийн Засаг даргаас 2016 онд дүүргийн Засаг дарга нартай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ	63	88	88	25	38	50	25	25	25	47	1.9
4	Дүүргийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	50	100	50	50	25	75	75	50	100	64	2.6
5	Дүүргийн Засаг дарга төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан захирамж, албан даалгавар	0	0	100	63	0	0	100	0	0	29	1.2
6	Дүүргийн ЗДТГ-ын дарга болон байгууллагын төсвийн шууд захирагч нар Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	63	25	25	25	63	100	38	38	63	49	1.9
7	Дүүргийн ЗДТГ-ын даргын СТСХ-ийн даргатай байгуулсан ҮДГ-д тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	38	75	25	25	0	25	0	25	25	26	1.1
8	Дүүргийн ЗДТГ-ын дарга болон СТСХ-ийн даргын гаргасан төсвийн ил тод байдалтай холбогдох албан бичиг, үүрэг даалгавар	50	0	0	0	0	0	0	25	0	8	0.3
9	Дүүргийн ИТХ болон иргэдээс төсвийн ил тод байдалд тавих хөндлөнгийн хяналтын журам, түүний хэрэгжилт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0.0
10	Дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас төсвийн ил тод байдалд тавих дотоод хяналтын журам, түүний хэрэгжилт	88	0	0	0	0	0	0	0	0	10	0.4
Нэгдсэн үнэлгээ		40.0	38.8	38.8	26.3	25.0	32.5	30.0	18.8	31.3	31.3	1.3
Авсан дундаж оноо		1.6	1.6	1.6	1.1	1.0	1.3	1.2	0.8	1.3	1.3	


Хавсралт 3. Орон нутаг тус бүрийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дүн /21 аймаг, нийслэл, 9 дүүрэг/

АРХАНГАЙ АЙМАГ

Төсвийн ил тод байдлын үнэлгээ

№	ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ, БАРИМТ БИЧИГ	ҮНЭЛГЭЭ		АЙМГУУДЫН ДУНДАЖ
		ОНОО	ХУВЬ	
1	Эрх зүйн баримт бичиг	1.25	31.3	37.7
2	Төсвийн төсөл	0.63	15.6	19.6
3	ИТХ-ын хуралдаан	2.50	62.5	47.3
4	Батлагдсан төсөв	1.76	44.0	60.4
5	Иргэний төсөв	0.00	0.0	0.0
6	Төсвийн тодотгол	0.75	18.8	36.4
7	Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа	1.45	36.4	52.3
8	Төсвийн гүйцэтгэл	2.57	64.3	65.6
9	Орон нутгийн хөгжлийн сан	0.67	16.7	21.7
10	Засаг даргын нөөц хөрөнгө	1.00	25.0	22.3
11	Орон нутгийн тусгай сангууд	3.00	75.0	58.7
12	Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт	1.00	25.0	45.6
Нэгдсэн үнэлгээ		1.38	34.5	39.0

Төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдал



Төсвийн баримт бичгийн ил тод байдлын үнэлгээ 2016

№	Төсвийн баримт бичигт тавигдах шаардлага	Үнэлгээ
2.	Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийн ил тод байдал	
2.1.	<i>2016 оны төсвийн санал, төсвийн төсөл (2015 оны 8 дугаар сарын 15-ны дотор дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн)</i>	
a.	Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны суурь төсвийн саналыг боловсруулах явцад иргэд, олон нийтэд танилцуулсан, мөн тэдний саналыг авсан байдал	0
b.	Аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох салбарын сайд, Сангийн яаманд 2016 оны төсвийн саналыг 2015 оны 8 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгож танилцуулсан байдал	0

c.	2016 оны аймаг, нийслэл, дүүргийн төсвийн төслийг 2015 оны 9 дүгээр сарын 15-ны дотор орон нутгийн болон Шилэн дансны цахим хуудсанд PDF форматаар байрлуулан иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлсэн байдал	3
2.2.	<i>Аймаг, нийслэлийн Засаг даргаас аймаг, нийслэлийн аудиторт хүргүүлсэн 2016 оны төсвийн төсөл (2015 оны 11 дүгээр сарын 10-ны дотор)</i>	
a.	Аймаг, нийслэлийн Засаг дарга 2016 оны төсвийн төслийг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн аудитор, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгосон байдал	0

2.3. Аймаг, нийслэлийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2016 оны төсвийн төсөл (2015 оны 11 дүгээр сарын 25-ны дотор)

a. Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийг боловсруулах явцдаа тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулсан байдал	0
b. Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийн талаар тухайн аймаг, нийслэлийн иргэдийн санал, хүсэлтийг тухайн шатны Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсан байдал	0
c. Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийг тухайн шатны Засаг дарга 2015 оны 11 дүгээр сарын 25-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ ил тод болгож, олон нийтэд танилцуулсан байдал	1
d. Аймаг, нийслэлийн аудитор 2016 оны төсвийн төслийн талаарх дүгнэлтийг ИТХ-д 2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлэхдээ ил тод болгосон байдал	1
Төсвийн төсөл	0.625

3. Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал (2015 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 5-ны дотор)

3.1. Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдааны нээлтэй байдал

a. Хуралдаан болсон огноо, газар, эхэлсэн, дууссан болон үргэлжилсэн хугацаа	3
b. Хуралдааны ирц	4
c. Хуралдааны хэлэлцсэн асуудлын жагсаалт, илтгэгчийн нэр, албан тушаал	4
d. Хуралдаанд иргэд, иргэний нийгэм, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байдал (Хэрвээ оролцуулсан бол 5 хүний нэр, ажил, албан тушаалын жагсаалтыг энд бичнэ)	1
e. Хуралдаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийг оролцуулж сурвалжлуулсан байдал (Хэрвээ оролцуулсан бол тэдгээр байгууллагын жагсаалтыг энд бичнэ)	3

f. Хуралдааныг радио, телевизээр шууд дамжуулсан эсэх (Хэрвээ тийм бол тухайн радио, телевизийн нэр, хаягийг бичнэ)	2
---	---

3.2. Хуралдааны баримт бичгийн ил тод байдал

a. Хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	4
b. Хуралдаанд тараасан илтгэл, танилцуулга зэрэг материалууд	1
c. Хуралдааны тогтоол, шийдвэр	1
d. Хуралдааны тэмдэглэл буюу протокол	2
ИТХ-ын хуралдаан	2.500

4. Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны батлагдсан төсвийн ил тод байдал

4.1. 2016 оны батлагдсан төсөв (2016 оны 1 дүгээр сарын 10-ны дотор)

a. Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны төсөв батлагдаж, хүчин төгөлдөр болсны дараа төсвийн ерөнхийлөн захирагч аймаг, нийслэл, дүүргийн төсвийг батлагдсан бүрэн эхээр нь (Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын хуралдааны төсөв батлах тухай тогтоол, төсвийн орлогын нэр төрөл, дүн, төсвийн зарлага, шилжүүлгийн хэмжээ, хөрөнгө оруулалтын жагсаалт, ОНХС-гаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан маягуудаар) 2016 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор олон нийтэд мэдээлсэн байдал	4
b. 2016 оны батлагдсан төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор ил тод болгохдоо аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ-ийн 2016 оны төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөөг ШДЦХТМАНСТЖ-ын 1-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал	0
c. 2016 оны батлагдсан төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор ил тод болгохдоо аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ-ийн 2016 оны төсвийн хөтөлбөр, батлагдсан төсвийн мэдээллийг ШДЦХТМАНСТЖ-ын 20-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал	4

d. 2016 оны батлагдсан төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор ил тод болгохдоо хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2016 оны төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг ШДЦХТМАНСТЖ-ын 3-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал	0.33
e. 2016 оны батлагдсан төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор ил тод болгохдоо Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын 2016 оны төлөвлөгөөг ШДЦХТМАНСТЖ-ын 2-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал	1
f. 2016 оны батлагдсан төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор ил тод болгохдоо аймаг, нийслэл, дүүргийн ОНХС-ийн 2016 оны төлөвлөгөөг ШДЦХТМАНСТЖ-ын 11-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал	3
<i>4.2. 2016 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь (2016 оны 12 дугаар сарын 31-ний дотор)</i>	
a. Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн сар, улирлын хуваарийг 12 дугаар сарын 25-ны дотор батлах, эсвэл 12 дугаар сарын 31-ний дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ ил тод болгож танилцуулсан эсэх	0
Батлагдсан төсөв	1.761
5. Иргэний төсөв	
a. 2016 оны төсвийн жишээн дээр иргэнд зориулсан төсвийг боловсруулж, мэдээлсэн байж болно.	0
Иргэний төсөв	0
6. Аймаг, нийслэл, дүүргийн 2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард хийсэн төсвийн тодотгол (хэрвээ тодотгол хийгдсэн бол)	
a. Хэрвээ 2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард төсвийн тодотгол хийгдсэн бол төслийг нь тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэхдээ олон нийтэд ил тод болгож танилцуулсан байдал	0
b. Тухайн төсвийн тодотголын төслийг хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны огноо, болсон газар, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хуралдааны илтгэл, танилцуулга, хуралдааны тэмдэглэл	1

c. Тухайн төсвийн тодотголын төслийг хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны нээлттэй байдал	1
d. Тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд батлагдсанаас хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАНСТЖ-ын 1, 20-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал	1
Төсвийн тодотгол	0.75

7. Аймаг, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал

7.1. 2015 оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан (2016 оны 1 дүгээр сарын 15-ны дотор)

a. Аймаг, нийслэлийн Засаг дарга 2015 оны худалдан авах ажиллагааны жилийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ ШДЦХТМАНСТЖ-ын 22-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсаар олон нийтэд танилцуулж, ил тод болгосон байдал	3
---	---

7.2. 2016 оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө (2016 оны 1 дүгээр сарын 10-ны дотор)

a. Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг 2016 оны 1 дүгээр сарын 10-ны дотор ШДЦХТМАНСТЖ-ын 21-р хавсралтын дагуу боловсруулж Шилэн дансны цахим хуудсанд мэдээлж, олон нийтэд ил тод болгосон байдал	3
--	---

7.3. 2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сарын худалдан авалтын явц, үр дүнгийн ил тод байдал

a. Аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь 2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард тухайн орон нутаг төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэж, санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж байсан байдал	1
--	---

b.	2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүрийн дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлж, сар бүрийн 8-ны дотор олон нийтэд танилцуулж, Шилэн дансны цахим хуудсанд байрлуулан ил тод болгосон байдал	1	g	2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар мэдээлж ил тод болгосон байдал	0
c.	Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл ТББ-ын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилсон иргэнийг оролцуулсан байдал	1	h	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард хийсэн худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАСТЖ-ын 8-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал	1
d.	Тухайн ажил, үйлчилгээний гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг байрлуулсан байдал	0	i	2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард хийгдсэн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАСТЖ-ын 9-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар ил тод болгосон байдал	3
e.	2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг Үнэлгээний хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАСТЖ-ын 7-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал	3	Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа		1.455
f.	2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАСТЖ-ын 10-р хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар мэдээлсэн байдал	0	8. Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн гүйцэтгэлийн ил тод байдал		
<i>8.1. 2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сар, улирал, хагас, бүтэн жилийн мэдээ (Сар бүрийн 8-ны дотор)</i>					
a.	2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сарын төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээг аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ дээд шатны байгууллагад хүргүүлж, дараа сарын 8-ны дотор ШДЦХТМАСТЖ-ын 2-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал	3	b.	2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сарын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээг аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ дээд шатны байгууллагад хүргүүлж, дараа сарын 8-ны дотор ШДЦХТМАСТЖ-ын 3-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал	3

с. 2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сарын улсын болон орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээг аймаг, нийслэл, дүүргийн ТЭЗ дээд шатны байгууллагад хүргүүлж, дараа сарын 8-ны дотор ШДЦХТМАСТЖ-ын 4-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал

1

8.2. 2015 оны төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайлан (2015 оны 8 дугаар сарын 15-ны дотор)

а. Аймаг, нийслэл, дүүргийн 2015 оны төсвийн хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ Шилэн дансны цахим хуудсанд PDF форматаар байрлуулж, ил тод болгож олон нийтэд хүргэсэн байдал

0

8.3. 2015 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан (2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор)

а. 2015 оны төсвийн гүйцэтгэлийг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор орон нутгийн цахим хуудас болон Шилэн дансны цахим хуудсанд цахимаар болон PDF форматаар байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал

4

8.4. 2015 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийсэн тайлан (2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор)

а. Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч 2015 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байрлуулан PDF форматаар нийтэд мэдээлсэн байдал

4

б. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар мэдээлсэн байдал

3

Төсвийн гүйцэтгэл

2.571

9. Аймаг, нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн ил тод байдал

9.1. Аймаг, нийслэлийн ОНХС-ийн 2016 оны төлөвлөлт (урьдчилсан жагсаалт, иргэд, олон нийтийн санал авах явц)

а. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, 2015 оны 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авсан байдал [2015 оны 9 дүгээр сарын 30-ны дотор]

0

б. Аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд, олон нийтэд танилцуулсан байдал [2015 оны 10, 11 дүгээр саруудад]

1

с. Аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан нэгдсэн жагсаалтыг гарган тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2016 оны төсвийн төслийн хамт өргөн мэдүүлэхдээ иргэд, олон нийтэд танилцуулсан байдал [2015 оны 11 дүгээр сарын 25-ны дотор]

0

9.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал асуулга явуулж, иргэд, олон нийтийн санал авах явц, урьдчилсан жагсаалт боловсруулж хэлэлцүүлэх, өргөн барих үйл явц, үр дүнгийн мэдээлэл

а. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар иргэдээс санал авсан, урьдчилсан жагсаалт гаргаж хэлэлцүүлсэн болон түүнийг шийдвэрлэсэн үйл явц, түүний ил тод, нээлттэй байдал

0

b. Сум, дүүргийн Засаг дарга баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас баталгаажсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүйгээс саналын жагсаалтыг тусад нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэхдээ ил тод болгосон байдал	0
--	---

c. ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаар цаг хугацаанд нь иж бүрэн, ил тод мэдээлсэн байдал	3
---	---

Орон нутгийн хөгжлийн сан	0.67
----------------------------------	-------------

а. ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар иргэдээс санал авсан, урьдчилсан жагсаалт гаргаж хэлэлцүүлсэн болон түүнийг шийдвэрлэсэн үйл явц, түүний ил тод, нээлттэй байдал	0
б. Дүүргийн Засаг дарга баг, хорооны ИНХ-аас баталгаажсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүйгээс саналын жагсаалтыг тусад нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэхдээ ил тод болгосон байдал	0
с. ОНХС-ийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаар цаг хугацаанд нь иж бүрэн, ил тод мэдээлсэн байдал	0
Орон нутгийн хөгжлийн сан	0.16667
10. Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгийн ил тод байдал (2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сар)	
а. Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаархи мэдээллийг тухайн шатны Засаг даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулахдаа 2015 оны 7, 10 дугаар сарын 20, 2016 оны 1, 4 дүгээр сарын 20-ны дотор олон нийтэд ил тод болгосон байдал	0
Засаг даргын нөөц хөрөнгө	0

11. Дүүргийн орон нутгийн тусгай сангуудын ил тод байдал (2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сар)	
а. 2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сард дүүрэг хөгжүүлэх сан, Замын сан, Жижиг дунд үйдвэрийг хөгжүүлэх сан зэрэг тусгай сангуудын орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, үлдэгдлийн сар (улирал, хагас болон бүтэн жил)-ын мэдээг дараа сарын 8-ны дотор ШДЦХТМАНСТЖ-ын 2-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсанд байрлуулж, олон нийтэд ил тод болгосон байдал	2
Орон нутгийн тусгай сангууд	2
12. Дүүргийн хандив, тусламжаар авсан хөрөнгө, түүний зарцуулалтын ил тод байдал (2015 оны 6-12 дугаар сар, 2016 оны 1-5 дугаар сар)	
а. Дүүргийн ТЕЗ хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгө, түүний зарцуулалтын 2015 оны хагас жилийн тайланг 2015 оны 8 дугаар сарын 15-ны дотор, ШДЦХТМАНСТЖ-ын 6-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн байдал	2
б. Дүүргийн ТЕЗ хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгө, түүний зарцуулалтын 2015 оны жилийн эцсийн тайланг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор ШДЦХТМАНСТЖ-ын 6-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн байдал	2
Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт	2

Хавсралт 4. Орон нутгийн төсвийн баримт бичгүүд болон төсвийн үйл явцын нээлттэй, ил тод байдлыг үнэлэхэд ашиглах шалгуур үзүүлэлт, түүнд харгалзах оноо

Төсвийн тухайн баримт бичиг:

Хугацаандаа, иж бүрэн ил тод болсон	4
Хугацаа хоцорсон ч бүрэн ил тод болсон, эсвэл хугацаандаа байсан ч мэдээлэл нь бүрэн бус	3
Хүсэлт, шаардлага тавьсны үндсэн дээр ил тод болсон	2
Бүрэн бус ч ямар нэгэн байдлаар мэдээлэл олж үзэх боломжтой	1
Огт ил тод болоогүй	0

Хавсралт 5. Асуулга

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ТӨСВИЙН МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ БИЧГИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЖ БҮРЭН БАЙДЛЫГ НОТЛОХ МАЯГТУУД

1. Төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдал

Төсвийн ил тод байдлын тухайд орон нутгийн түвшинд гаргасан тогтоол, захирамж, шийдвэр зэрэг албан ёсны баримт бичиг	<ol style="list-style-type: none">1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хуудасны тоо2. Уг баримт бичгээс төсвийн ил тод, нээлттэй байдлын холбогдолтой бүлэг, зүйл, заалт, эшлэлийг хуулж оруулах.3. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана).4. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар (цахим хуудаснаас авсан бол холбоосыг бичих)5. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
Орон нутгийн бодлогын баримт бичигт төсвийн ил тод байдлыг тусгасан эсэх (Тухайлбал, аймаг, нийслэл, дүүргийн нийгэм, эдийн засгийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилт)	
Аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал ба Тэргүүлэгчдийн хурлаас төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан тогтоол, шийдвэр	
Аймаг, нийслэлийн Засаг даргын 2016 онд салбарын Төсвийн ерөнхийлөн захирагч нартай, Нийслэлийн Засаг даргаас дүүргийн Засаг дарга нартай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ	
Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	
Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой гаргасан захирамж, албан даалгавар	
Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга болон байгууллагын төсвийн шууд захирагч нар Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	
Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын даргын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусгагдсан төсвийн ил тод байдалтай холбоотой заалт	
Аймгийн ЗДТГ-ын дарга болон Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын гаргасан төсвийн ил тод байдалтай холбогдох албан бичиг, үүрэг даалгавар	
Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ болон иргэдээс төсвийн ил тод байдалд тавих хөндлөнгийн хяналтын журам, түүний хэрэгжилт	
Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас төсвийн ил тод байдалд тавих дотоод хяналтын журам, түүний хэрэгжилт	
Бусад	

2. Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийн ил тод байдал

2.1. 2016 оны төсвийн санал, төсвийн төсөл (2015 оны 8-р сарын 15-ны дотор дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

3.1. “Төсвийн тухай хуулийн 27.5-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 5-ны өдрийн дотор төсвийн удирдамжийг хүргүүлнэ”

4.3. Орон нутгийн суурь төсвийн саналыг дараах цаглабарын дагуу боловсруулж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ:

4.3.1. орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсөвт байгууллагын төсвийн захирагч сум, дүүргийн Засаг даргад суурь төсвийн саналыг жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ;

4.3.2. сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ;

4.3.3. аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид жил бүрийн 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор, орон нутгийн төсөвт байгууллагын суурь төсвийн саналыг санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад, үүнээс удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн суурь зардлын саналыг хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор тус тус хүргүүлнэ;

“Шилэн дансны тухай хууль”:

6.1.3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан тушаалтан дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9-р сарын 15-ны өдрийн дотор мэдээнэ.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээнэ:

3.1.16. Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар.

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none">1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана)3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	---

Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны суурь төсвийн саналыг боловсруулах явцад иргэд, олон нийтэд танилцуулсан, мөн тэдний саналыг авсан байдал

Аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох салбарын сайд, Сангийн яаманд 2016 оны төсвийн саналыг 2015 оны 8-р сарын 15-ны дотор хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгож танилцуулсан байдал

2016 оны аймаг, нийслэл, дүүргийн төсвийн төслийг 2015 оны 9-р сарын 15-ны дотор орон нутгийн болон Шилэн дансны цахим хуудсанд PDF форматаар байрлуулан иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал

2.2. *Аймаг, нийслэлийн Засаг даргаас аймаг, нийслэлийн аудиторт хүргүүлсэн 2016 оны төсвийн төсөл (2015 оны 11-р сарын 10-ны дотор)*

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд
“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

7.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны төсвийн төслийг аймаг, нийслэлийн аудитор, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлнэ.

Төсвийн баримт бичиг	<ol style="list-style-type: none">1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана).3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
----------------------	---

Аймаг, нийслэлийн Засаг дарга 2016 оны төсвийн төслийг 2015 оны 11-р сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн аудитор, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгосон байдал

2.3. *Аймаг, нийслэлийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2016 оны төсвийн төсөл (2015 оны 11-р сарын 25-ны дотор)*

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд
“Төсвийн тухай хууль”:

8.5.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

67 дугаар зүйл. Орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх

67.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

67.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

7.4. Аймаг, нийслэлийн аудитор жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

“Төсвийн тухай хууль”:

67.2. Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

67.2.1. орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;

67.2.2. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга;

67.2.3. аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн санал;

67.2.4. дээд шатны төсөвт тусган баталсан дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

7.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсвийн төслийг энэ журмын 5.1-д заасан мэдээлэлд үндэслэн Төсвийн тухай хуулийн 33.2-т заасны дагуу боловсруулж, мөн хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

7.5. Аймаг, нийслэлийн жилийн төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 33.2-т заасныг дор дурдсан байдлаар тусгана

“Төсвийн тухай хууль”:

33.2.Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална:

33.2.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого;

33.2.2.төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ, үүнээс тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ;

33.2.3.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын шинээр үүсгэх өр, гаргах баталгааны дээд хязгаар, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалт;

33.2.4.бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг;

33.2.5.төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар;

33.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана).
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийг боловсруулах явцдаа тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулсан байдал

Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийн талаар тухайн аймаг, нийслэлийн иргэдийн санал, хүсэлтийг тухайн шатны Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсан байдал

Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийг тухайн шатны Засаг дарга 2015 оны 11-р сарын 25-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ ил тод болгож, олон нийтэд танилцуулсан байдал

Аймаг, нийслэлийн аудитор 2016 оны төсвийн төслийн талаарх дүгнэлтийг ИТХ-д 2015 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлэхдээ ил тод болгосон байдал

2.3. Дүүргийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2016 оны төсвийн төсөл (2015 оны 12-р сарын 10-ны дотор)*

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

ТТХ 8.5.3. Сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэх;

67 дугаар зүйл. Орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх

67.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

67.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

Арга хэлбэр буюу загвар:

“Төсвийн тухай хууль”:

67.2. Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

67.2.1. орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;

67.2.2. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга;

67.2.3. аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн санал;

67.2.4. дээд шатны төсөвт тусган баталсан дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

7.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсвийн төслийг энэ журмын 5.1-д заасан мэдээлэлд үндэслэн Төсвийн тухай хуулийн 33.2-т заасны дагуу боловсруулж, мөн хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

7.5. Аймаг, нийслэлийн жилийн төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 33.2-т заасныг дор дурдсан байдлаар тусгана

“Төсвийн тухай хууль”:

33.2.Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална:

33.2.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого;

33.2.2.төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ, үүнээс тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ;

33.2.3.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын шинээр үүсгэх өр, гаргах баталгааны дээд хязгаар, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалт;

33.2.4.бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг;

33.2.5.төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар;

33.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

Төсвийн баримт бичиг ба үйл явц	5. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ 6. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана). 7. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 8. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	--

Дүүргийн 2016 оны төсвийн төслийг боловсруулах явцдаа дүүргийн Засаг дарга олон нийтэд танилцуулсан байдал

Дүүргийн 2016 оны төсвийн төслийн талаар тухайн дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсан байдал

Дүүргийн 2016 оны төсвийн төслийг дүүргийн Засаг дарга 2015 оны 12-р сарын 10-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ ил тод болгож, олон нийтэд танилцуулсан байдал

3. Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал (2015 оны 11-р сарын 25-наас 12-р сарын 5-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

8.5.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 5-ны дотор батлах;

Хуралдааны нээлттэй байдал	Тайлбар ба нотолгоог бичнэ. Шаардлагатай бол нотлох баримтыг хавсаргана.
----------------------------	---

Хуралдаан болсон огноо, газар, эхэлсэн, дууссан болон үргэлжилсэн хугацаа

Хуралдааны ирц

Хуралдааны хэлэлцсэн асуудлын жагсаалт, илтгэгчийн нэр, албан тушаал

Хуралдаанд иргэд, иргэний нийгэм, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байдал (Хэрвээ оролцуулсан бол 5 хүний нэр, ажил, албан тушаалын жагсаалтыг энд бичнэ)

Хуралдаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийг оролцуулж сурвалжлуулсан байдал (Хэрвээ оролцуулсан бол тэдгээр байгууллагын жагсаалтыг энд бичнэ)

Хуралдааныг радио, телевизээр шууд дамжуулсан эсэх (Хэрвээ тийм бол тухайн радио, телевизийн нэр, хаягийг бичнэ)

Хуралдааны баримт бичгийн ил тод байдал	<ol style="list-style-type: none"> Иргэд, олон нийт дээрх баримт бичиг, материалыг хэзээ, хаанаас буюу хэнээс, хэрхэн олж авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана) Судлаач өөрөө хуралдааны баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---	--

Хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө

Хуралдаанд тараасан илтгэл, танилцуулга зэрэг материалууд

Хуралдааны тогтоол, шийдвэр

Хуралдааны тэмдэглэл буюу протокол

3*. Дүүргийн 2016 оны төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал (2015 оны 12-р сарын 10-наас 12-р сарын 20-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

ТТХ 8.5.4. Сум, дүүргийн ИТХ тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор батлах;

Хуралдааны нээлттэй байдал	Тайлбар ба нотолгоог бичнэ. Шаардлагатай бол нотлох баримтыг хавсаргана.
----------------------------	---

Хуралдаан болсон огноо, газар, эхэлсэн, дууссан болон үргэлжилсэн хугацаа

Хуралдааны ирц

Хуралдааны хэлэлцсэн асуудлын жагсаалт, илтгэгчийн нэр, албан тушаал	
Хуралдаанд иргэд, иргэний нийгэм, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байдал (Хэрвээ оролцуулсан бол 5 хүний нэр, ажил, албан тушаалын жагсаалтыг энд бичнэ)	
Хуралдаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийг оролцуулж сурвалжлуулсан байдал (Хэрвээ оролцуулсан бол тэдгээр байгууллагын жагсаалтыг энд бичнэ)	
Хуралдааныг радио, телевизээр шууд дамжуулсан эсэх (Хэрвээ тийм бол тухайн радио, телевизийн нэр, хаягийг бичнэ)	
Хуралдааны баримт бичгийн ил тод байдал	<ol style="list-style-type: none"> 1. Иргэд, олон нийт дээрх баримт бичиг, материалыг хэзээ, хаанаас буюу хэнээс, хэрхэн олж авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана) 2. Судлаач өөрөө хуралдааны баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 3. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
Хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	
Хуралдаанд тараасан илтгэл, танилцуулга зэрэг материалууд	
Хуралдааны тогтоол, шийдвэр	
Хуралдааны тэмдэглэл буюу протокол	

4. Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны батлагдсан төсвийн ил тод байдал

4.1. 2016 оны батлагдсан төсөв (2016 оны 1-р сарын 10-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

“Шилэн дансны тухай хууль”:

6.1. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

6.1.1. Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

“Төсвийн тухай хууль”:

68.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

Батлагдсан төсөв бүрэн эхээрээ, хавсралтуудын хамт. Үүнд:

1.Төсөв батлах тухай тогтоол

2.Төсвийн төлөвлөгөө (орлого зарлагын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө)

3. Хавсралтууд

“Төсвийн тухай хууль”:

68.1. Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална.

33.2. Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална:

33.2.1. төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого;

33.2.2. төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ, үүнээс тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ;

33.2.3. төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын шинээр үүсгэх өр, гаргах баталгааны дээд хязгаар, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалт;

33.2.4. бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг;

33.2.5. төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар;

33.2.6. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

33.2.7. концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, тэдгээрт тавигдах тусгай шаардлага, нөхцөлийг хавсралтаар

68.2. Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

Нэг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийг батлагдсан бүрэн эхээр нь ил тод болгоно. Энэ нь “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын хавсралт загвар, маягтуудын дагуу батлагдсан баримт бичгүүд байх юм.

Үүнд:

1. Хавсралт №2аймаг/нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоол. Загвар маягт. “ ... аймаг/нийслэлийн оны төсөв батлах тухай.

Мөн тус тогтоолын хавсралтад заасан загвар, маягтуудын дагуу батлагдсан бусад баримт бичгүүд байна.

Үүнд:

2. “Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн” (... аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны ..-р тогтоолын 1 дүгээр хавсралт)”,

3. “...аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт (... аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны ..-р тогтоолын 2 дугаар хавсралт),

4. “...аймаг/нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт” (... аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны ..-р тогтоолын 3 дугаар хавсралт),

5. “...сум/дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоол (загвар маягт) “.... сум/дүүргийн оны төсөв батлах тухай”,

6. “Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн” (...сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны ..-р тогтоолын 1 дүгээр хавсралт)”

7. “...сум/дүүргийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт (... сум/дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны ..-р тогтоолын 2 дугаар хавсралт),

8. “...сум/дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт” (... сум/дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны ..-р тогтоолын 3 дугаар хавсралт),

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.1. төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.1.2. төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсвийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.1.4. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор энэ журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.1.8. Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.1.14. худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор цахимаар;

3.1.15. орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны энэ журмын 11 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none"> 1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ 2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана) 3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	---

Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны төсөв батлагдаж, хүчин төгөлдөр болсны дараа төсвийн ерөнхийлөн захирагч аймаг, нийслэл, дүүргийн төсвийг батлагдсан бүрэн эхээр нь (Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ-ын хуралдааны төсөв батлах тухай тогтоол, төсвийн орлогын нэр төрөл, дүн, төсвийн зарлага, шилжүүлгийн хэмжээ, хөрөнгө оруулалтын жагсаалт, ОНХС-гаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан маягтуудаар) 2016 оны 1-р сарын 10-ны өдрийн дотор олон нийтэд мэдээлсэн байдал

2016 оны батлагдсан төсвийг 1-р сарын 10-ны дотор ил тод болгохдоо аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ-ийн 2016 оны төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөөг ШДЦХТМАНСТЖ-ын 1-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал

2016 оны батлагдсан төсвийг 1-р сарын 10-ны дотор ил тод болгохдоо аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ-ийн 2016 оны төсвийн хөтөлбөр, батлагдсан төсвийн мэдээллийг ШДЦХТМАНСТЖ-ын 20-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал

2016 оны батлагдсан төсвийг 1-р сарын 10-ны дотор ил тод болгохдоо хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2016 оны төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг ШДЦХТМАНСТЖ-ын 3-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал

2016 оны батлагдсан төсвийг 1-р сарын 10-ны дотор ил тод болгохдоо Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын 2016 оны төлөвлөгөөг ШДЦХТМАНСТЖ-ын 2-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал

2016 оны батлагдсан төсвийг 1-р сарын 10-ны дотор ил тод болгохдоо аймаг, нийслэл, дүүргийн ОНХС-гийн 2016 оны төлөвлөгөөг ШДЦХТМАНСТЖ-ын 11-р хавсралтад тусгасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал

4.2. 2016 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь (2016 оны 12-р сарын 31-ний дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

8.7. Аймаг, нийслэлийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална.

8.7.1. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор батлах

8.7.2. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

Арга хэлбэр буюу загвар:

Бүрэн эхээр нь:

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэлийн 2016 оны төсвийн сар, улирлын хуваарийг 12-р сарын 25-ны дотор батлах, эсвэл 12-р сарын 31-ний дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ ил тод болгож танилцуулсан эсэх

5. Иргэний төсөв

Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

2016 оны байдлаар Монгол Улсын хууль тогтоомжид Иргэний төсвийн тухай заалт байхгүй.

Гэхдээ аймаг, нийслэлийн түвшинд өөрийн санаачилгаар болон бусад байгууллагатай хамтран иргэдэд зориулсан төсвийн баримт бичиг боловсруулж гаргах боломжтой бөгөөд тэгсэн тохиолдолд үнэлнэ.

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

2016 оны төсвийн жишээн дээр иргэнд зориулсан төсвийг боловсруулж, мэдээлсэн байж болно.

6. Аймаг, нийслэл, дүүргийн 2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард хийсэн төсвийн тодотгол (хэрвээ тодотгол хийгдсэн бол)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 1, 20 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимгаар;

“Орон нутгийн төсөв боловсруулах журам”:

Арав. Төсвийн тодотголын төсөл боловсруулах

10.1. Төсвийн тодотголын төслийг Төсвийн тухай хуулийн 34.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд боловсруулна.

10.2. Дээд шатны төсөвт тодотгол орсны улмаас доод шатны төсвийн захирагч батлагдсан төсөвтөө зайлшгүй тодотгол оруулах шаардлагатай гэж үзвэл дээд шатны төсөвт тодотгол орсноос хойш 45 хоногт багтааж төсвийн тодотголын төслийг боловсруулж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

10.3. Төсвийн тодотголын төслийг зөвхөн нэмэлт, өөрчлөлт оруулж буй зүйлийг энэ журмын 7 дугаар зүйлд заасны дагуу боловсруулж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

10.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн тодотголын төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэн баталснаас хойш 30 өдрийн дотор сар, улирлын хуваарийг баталж, нэгтгэн, санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Хэрвээ 2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард төсвийн тодотгол хийгдсэн бол төслийг нь тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэхдээ олон нийтэд ил тод болгож танилцуулсан байдал

Тухайн төсвийн тодотголын төслийг хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны огноо, болсон газар, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хуралдааны илтгэл, танилцуулга, хуралдааны тэмдэглэл

Тухайн төсвийн тодотголын төслийг хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны нээлттэй байдал

Тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд батлагдсанаас хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАНСТЖ-ын 1, 20-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

7. Аймаг, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал

7.1. 2015 оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан (2016 оны 1-р сарын 15-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”:

3.6.Төсвийн ерөнхийлөн захирагч хуулийн 45.1 дэх, 45.2.1 дэх заалтыг үндэслэн батлагдсан багцын хүрээнд өөрийн хэрэгцээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэрэгжилтийн, мөн хуулийн 45.4 дэх заалтын дагуу Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь тухайн оны худалдан авах ажиллагааны тайланг Маягт 2, 3-ын дагуу нэгтгэн хуулийн 49.5-д заасны дагуу дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

Сангийн сайдын 2012 оны 12-р сарын 13-ны өдрийн 264 тоот тушаалаар баталсан “Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 1-р хавсралтын “Захиалагчийн ... оны бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын тайлан” маягт №2, 3-ын дагуу.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.14. худалдан авах ажиллагааны ... жилийн тайланг энэ журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэлийн Засаг дарга 2015 оны худалдан авах ажиллагааны жилийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ ШДЦХТМАНСТЖ-ын 22-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсаар олон нийтэд танилцуулж, ил тод болгосон байдал

7.2. 2016 оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө (2016 оны 1-р сарын 10-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”:

48.5.Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

Батлагдсан бүрэн эхээр нь, дэлгэрэнгүй жагсаалт хэлбэрээр ил тод болгоно. Ингэхдээ, Сангийн сайдын 2012.12.13-ны 264-р тогтоолоор батлагдсан “Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын хавсралт №1 буюу “Захиалагчийн ... онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө маягтыг баримтлана.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.14. худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэл, дүүргийн 2016 оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг 2016 оны 1-р сарын 10-ны дотор ШДЦХТМАНСТЖ-ын 21-р хавсралтын дагуу боловсруулж Шилэн дансны цахим хуудсанд мэдээлж, олон нийтэд ил тод болгосон байдал

7.3. 2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сарын худалдан авалтын явц, үр дүнгийн ил тод байдал

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”

(Сангийн сайдын 2012.12.27-ны 290-р тушаалаар батлагдсан):

3.29. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэх бөгөөд санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж байна.

4.5. Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй ажлын санхүүжилт, түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар төсвийн эрх захирагч, тухайн нутгийн захиргааны байгууллагаас орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудыг хөндлөнгийн хяналт тавих боломжоор хангах үүрэгтэй.

6.3. Төсвийн өрөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүр энэ журмын тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, сар бүрийн дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

Сангийн сайдын 2012.12.27-ны 290-р тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын Хавсралт №5 буюу “..... Аймаг/сумын нутагт улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилгын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн –р сарын мэдээ” маягтын дагуу.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”:

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны хуулиар нарийвчлан зохицуулна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”:

47.4. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”

46.1. Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна:

46.1.9. Гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах.

“Шилэн дансны тухай хууль”:

6.4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан тушаалтан дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:

6.4.3. тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.4. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.1.6. хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.1.7. зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар;

3.1.13. худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар;

3.2. Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.2.5. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;

3.2.8. хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;

3.2.9. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.2.10. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.2.11. зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар;

3.2.16. худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг, гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь 2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэж, санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж байсан байдал

2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүрийн дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлж, сар бүрийн 8-ны дотор олон нийтэд танилцуулж, Шилэн дансны цахим хуудсанд байрлуулсан ил тод болгосон байдал

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл ТББ-ын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилсон иргэнийг оролцуулсан байдал

Тухайн ажил, үйлчилгээний гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг байрлуулсан байдал

2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард хөрөнгийн болон урсгал зардалд тусгасан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг Үнэлгээний хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАСТЖ-ын 7-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал

2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАСТЖ-ын 10-р хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар мэдээлсэн байдал

2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар мэдээлж ил тод болгосон байдал

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард хийсэн худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАСТЖ-ын 8-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар мэдээлсэн байдал

2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард хийгдсэн цалингийн зардаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор ШДЦХТМАСТЖ-ын 9-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар ил тод болгосон байдал

8. Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн гүйцэтгэлийн ил тод байдал

8.1. 2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сарын төсвийн гүйцэтгэлийн сар, улирал, хагас, бүтэн жилийн мэдээ (Сар бүрийн 8-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

8.8. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв, аймаг, нийслэлийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална.

8.8.1. төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх;

8.8.2. төсвийн төвлөрүүлэн захирагч тусгай сан, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 04-ний дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

8.8.3. төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 06-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

“Шилэн дансны тухай хууль”:

6.1.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан тушаалтан сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 8-ны өдрийн дотор тогтмол мэдээлнэ.

6.3. Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:

6.3.2. Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт;

6.3.3. Төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар;

6.3.8. Тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт;

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.2. ТЕЗ-ийн төсвийн ... гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 20 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.1.4. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ... гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.1.5. улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын ... гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сарын төсвийн гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээг аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ дээд шатны байгууллагад хүргүүлж, дараа сарын 8-ны дотор ШДЦХТМАСТЖ-ын 2-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал

2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сарын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээг аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ дээд шатны байгууллагад хүргүүлж, дараа сарын 8-ны дотор ШДЦХТМАСТЖ-ын 3-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал

2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сарын улсын болон орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийн сар (улирал, хагас, бүтэн жил)-ын мэдээг аймаг, нийслэл, дүүргийн ТЕЗ дээд шатны байгууллагад хүргүүлж, дараа сарын 8-ны дотор ШДЦХТМАСТЖ-ын 4-р хавсралтад заасан маягтын дагуу цахимаар олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал

8.2. 2015 оны төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайлан (2015 оны 8-р сарын 15-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

8.9.1. Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх

8.9.2. ТТЗ хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж ТЕЗ-д хүргүүлэх

8.9.5. төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

“Шилэн дансны тухай хууль”:

6.1.2. хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор мэдээлнэ.

6.1.4. хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор мэдээлнэ.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.9. хагас жилийн санхүүгийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор ... цахимаар болон PDF форматаар;

3.2. Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.2.6. өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор ... энэ журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу ... цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэл, дүүргийн 2015 оны төсвийн хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ Шилэн дансны цахим хуудсанд PDF форматаар байрлуулж, ил тод болгож олон нийтэд хүргэсэн байдал

8.3. 2015 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан (2016 оны 4-р сарын 25-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

8.9.1. Төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх

8.9.2. Төсвийн төвлөрүүлэн захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 5-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ... хүргүүлэх

8.9.4. Аймаг, нийслэлийн ТЕЗ жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх

“Шилэн дансны тухай хууль”:

6.1.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан тушаалтан ... өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 4-р сарын 25-ны өдрийн дотор тогтмол мэдээлнэ.

6.1.4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан тушаалтан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4-р сарын 25-ны өдрийн дотор мэдээлнэ.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.1. төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн ... жилийн эцсийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

3.1.9. ... жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор цахимаар болон PDF форматаар;

3.2. Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.2.6. өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан ... жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэ журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу ... цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

2015 оны төсвийн гүйцэтгэлийг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор орон нутгийн цахим хуудас болон Шилэн дансны цахим хуудсанд цахимаар болон PDF форматаар байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал

8.4. 2015 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийсэн тайлан (2016 оны 4-р сарын 25-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

8.9.4. аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;

8.9.5. төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

“Шилэн дансны тухай хууль”:

6.1.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 4-р сарын 25-ны өдрийн дотор мэдээлнэ.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.10. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор PDF форматаар;

3.1.11. аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч 2015 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор Шилэн дансны цахим хуудсанд байрлуулан PDF форматаар нийтэд мэдээлсэн байдал

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2015 оны 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар мэдээлсэн байдал

9. Аймаг, нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн ил тод байдал

9.1. Аймаг, нийслэлийн ОНХС-гийн 2016 оны төлөвлөлт (урьдчилсан жагсаалт, иргэд, олон нийтийн санал авах явц)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

63.1. Баг, хорооны Засаг дарга ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

63.2. Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ дээр гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

6.3. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараах зүйлсийг баримтална:

6.3.5. иргэдийн оролцоог хангасан байх;

Арван хоёр. Төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах.

12.1. Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:

12.1.1. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна;

12.1.2. иргэд, олон нийтийн саналыг цахим хуудас, санал асуулгын хуудас ашиглах, ярилцлага зохион байгуулах болон дэвшилтэт технологийн бусад хэлбэр ашиглах замаар явуулна;

12.1.3. аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд, олон нийтэд танилцуулна;

12.1.4. аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн чиг үүрэгт хамаарах асуудлын урьдчилсан жагсаалтыг олон нийтээр хэлэлцүүлж, баталгаажуулах үйл ажиллагааг сум, дүүргийн нэгдсэн жагсаалт боловсруулах үйл ажиллагаатай хамтад нь явуулж болно;

12.1.5. аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-д заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д (Сангийн сайдын 2012.11.19-ны 244-р тушаалаар баталсан) заасан загвар, маягтуудын дагуу ил тод, нээлттэй болгоно.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.15. орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 11 дүгээр хавсралтад заасан маягын дагуу тус тус цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, 2015 оны 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авсан байдал

[2015 оны 9-р сарын 30-ны дотор]

Аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд, олон нийтэд танилцуулсан байдал [2015 оны 10, 11-р саруудаа]

Аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан нэгдсэн жагсаалтыг гарган тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2016 оны төсвийн төслийн хамт өргөн мэдүүлэхдээ иргэд, олон нийтэд танилцуулсан байдал

[2015 оны 11-р сарын 25-ны дотор]

9.1. Дүүргийн ОНХС-гийн 2016 оны төлөвлөлт (урьдчилсан жагсаалт, иргэд, олон нийтийн санал авах явц)*

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

63.1. Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

63.2. Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны ИНХ дээр гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

6.3. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараах зүйлсийг баримтална:

6.3.5. иргэдийн оролцоог хангасан байх;

Арван хоёр. Төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах.

12.2.1. баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна:

12.2.1. 6/ саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягыг ашиглах ба маягыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ; [Энэ нь 3-р сарын 31-ны дотор гэсэн үг юм]

12.2.1. в/энэ журмын 12.2.1.а-т заасан хэлбэрээр санал асуулгыг явуулахдаа, жил бүрийн 2 дугаар улирлын эхний 30 өдөрт багтаан санал авна. [Энэ нь 4-р сарын 30-ны дотор гэсэн үг юм]

12.2.3. баг, хорооны Засаг дарга иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас 2 долоо хоногийн өмнө тухайн сум, дүүрэгт хуваарилагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо, иргэдээс гаргасан саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн тухайн сум, дүүрэг, баг хороонд хэрэгжүүлэх шаардлагатай хөгжлийн бодлого чиглэлтэй уялдсан төслүүдийн мэдээлэл, өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх товч мэдээллийг баг, хороодод байршуулсан байна; [Энэ нь 6-р сарын 15-наас өмнө гэсэн үг юм]

12.2.4. баг, хорооны Засаг дарга иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг тухайн иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж, тус хурлаас эрэмбэлэгдэн гарсан төслийн жагсаалтыг сум, дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлнэ; [Энэ нь 6-р сарын 30-ны дотор гэсэн үг юм]

12.2.5. сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхын санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална:

12.2.5. 6/ сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төслийн саналын төсвийн нөлөөллийн тооцоог боловсруулж хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 60 өдөрт нэгтгэн боловсруулна. [Энэ нь 8-р сарын 30-ны дотор гэсэн үг юм]

12.2.6. сум, дүүргийн Засаг дарга олон нийтээс авсан саналын дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг олон нийтэд танилцуулан, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж болно;

12.2.7. сум, дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ [Энэ нь төсвийн тухай хуулиар, 12-р сарын 10-ны дотор гэсэн үг];

Арга хэлбэр буюу загвар:

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д (Сангийн сайдын 2012.11.19-ны 244-р тушаалаар баталсан) заасан загвар, маягтуудын дагуу ил тод, нээлттэй болгоно.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.15. орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 11 дүгээр хавсралтад заасан маягын дагуу тус тус цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

5. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
6. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
7. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
8. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Хорооны Засаг дарга иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг тухайн иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж, тус хурлаас эрэмбэлэгдэн гарсан төслийн жагсаалтыг дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлэхэд ил тод болгосон байдал [2015 оны 6-р сарын 30-ны дотор]

Дүүргийн ЗДТГ нь хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхын санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцалж, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төслийн саналын төсвийн нөлөөллийн тооцоог боловсруулж хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 60 өдөрт нэгтгэн боловсруулж, ил тод болгосон байдал [2015 оны 8-р сарын 30-ны дотор]

Дүүргийн Засаг дарга олон нийтээс авсан саналын дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг олон нийтэд танилцуулан, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулсан байдал [2015 оны 9, 10-р саруудад]

Дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, журамд заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, дүүргийн ИТХ-д төсвийн төслийн хамт өргөн мэдүүлэхдээ иргэд, олон нийтэд танилцуулсан байдал [2015 оны 12-р сарын 10-ны дотор]

9.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал асуулга явуулж, иргэд, олон нийтийн санал авах явц, урьдчилсан жагсаалт боловсруулж хэлэлцүүлэх, өргөн барих үйл явц, үр дүнгийн мэдээлэл

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

12.2.1. баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна:

12.2.1. 6/ саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягыг ашиглах ба маягыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ; [Энэ нь 3-р сарын 31-ны дотор гэсэн үг юм]

12.2.1. в/энэ журмын 12.2.1.а-т заасан хэлбэрээр санал асуулгыг явуулахдаа, жил бүрийн 2 дугаар улирлын эхний 30 өдөрт багтаан санал авна. [Энэ нь 4-р сарын 30-ны дотор гэсэн үг юм]

12.2.3. баг, хорооны Засаг дарга иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас 2 долоо хоногийн өмнө тухайн сум, дүүрэгт хуваарилагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо, иргэдээс гаргасан саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн тухайн сум, дүүрэг, баг хороонд хэрэгжүүлэх шаардлагатай хөгжлийн бодлого чиглэлтэй уялдсан төслүүдийн мэдээлэл, өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх товч мэдээллийг баг, хороодод байршуулсан байна; [Энэ нь 6-р сарын 15-наас өмнө гэсэн үг юм]

12.2.4. баг, хорооны Засаг дарга иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг тухайн иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж, тус хурлаас эрэмбэлэгдэн гарсан төслийн жагсаалтыг сум, дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлнэ; [Энэ нь 6-р сарын 30-ны дотор гэсэн үг юм]

12.2.5. сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхын санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцална:

12.2.5. 6/ сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төслийн саналын төсвийн нөлөөллийн тооцоог боловсруулж хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 60 өдөрт нэгтгэн боловсруулна. [Энэ нь 8-р сарын 30-ны дотор гэсэн үг юм]

12.2.6. сум, дүүргийн Засаг дарга олон нийтээс авсан саналын дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг олон нийтэд танилцуулан, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж болно;

12.2.7. сум, дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ [Энэ нь төсвийн тухай хуулиар, 12-р сарын 10-ны дотор гэсэн үг];

12.2.8. сум, дүүргийн Засаг дарга баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас баталгаажсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй бол саналын жагсаалтыг тусад нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж болно;

Арга хэлбэр буюу загвар:

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын (Сангийн сайдын 2012.11.19-ны 244-р тушаалаар баталсан) хавсралтад заасан дараах загвар, маягтуудын дагуу ил тод болгоно. Үүнд:

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 1-р хавсралтад заасан “Орон нутгийн хөгжлийн сан. Иргэдээс санал авах маяг” байна.

2-р хавсралт. Баг/хорооны Иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл (ОНХС-гийн төсөл, арга хэмжээг хэлэлцэхэд ашиглах маяг)

3-р хавсралт. Орон нутгийн хөгжлийн сан. Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тодорхойлох маягт.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.15. орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 11 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар иргэдээс санал авсан, урьдчилсан жагсаалт гаргаж хэлэлцүүлсэн болон түүнийг шийдвэрлэсэн үйл явц, түүний ил тод, нээлтэй байдал

Сум, дүүргийн Засаг дарга баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас баталгаажсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүйгээс саналын жагсаалтыг тусад нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэхдээ ил тод болгосон байдал

ОНХС-гийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаар цаг хугацаанд нь иж бүрэн, ил тод мэдээлсэн байдал

10. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгийн ил тод байдал (2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сар)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”

(Сангийн сайдын 2012.11.15-ны 239 тоот тушаалаар батлагдсан):

“Тухайн шатны Засаг даргын тамгын газрын Санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэс (тасаг) Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаарх мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулж байна”.

Арга хэлбэр буюу загвар:

Засаг даргын зөвлөлийн хуралд хийсэн танилцуулгыг бүрэн эхээр нь буюу задаргаатай жагсаалт хэлбэрээр. Өмнөх оны 4-р улирлын тайлан нь жилийн тайлан байна.

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none">1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана)3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	---

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаарх мэдээллийг тухайн шатны Засаг даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулахдаа 2015 оны 7, 10-р сарын 20, 2016 оны 1, 4-р сарын 20-ны дотор олон нийтэд ил тод болгосон байдал

11. Аймаг, нийслэл, дүүргийн орон нутгийн тусгай сангуудын ил тод байдал (2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сар)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

8.8.2. Төсвийн төвлөрүүлэн захирагч тусгай сан, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 4-ний дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх

“Шилэн дансны тухай хууль”:

6.1.2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан тушаалтан сар, улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 8-ны өдрийн дотор тогтмол мэдээлнэ.

6.3. Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:

6.3.8. тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.1.8. Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Тухайн аймгийн орон нутгийн тусгай сангуудын албан ёсны нэр, жагсаалт, товч тодорхойлолт
2. Орон нутгийн тусгай сангуудын дүрэм журмын албан ёсны нэр, баталсан субъект, огноо (Хавсаргана)
3. Орон нутгийн тусгай сангуудын зарцуулалт, үлдэгдлийн талаарх тайлан, танилцуулга зэрэг баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
4. Иргэд, олон нийт тухайн мэдээлэл, баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
5. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
6. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сард Аймаг, нийслэл, дүүрэг хөгжүүлэх сан, Замын сан, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан зэрэг тусгай сангуудын орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, үлдэгдлийн сар (улирал, хагас болон бүтэн жил)-ын мэдээг дараа сарын 8-ны дотор ШДЦХТМАНСТЖ-ын 2-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсанд байрлуулж, олон нийтэд ил тод болгосон байдал

12. Аймаг, нийслэл, дүүргийн хандив, тусламжаар авсан хөрөнгө, түүний зарцуулалтын ил тод байдал (2015 оны 6-12-р сар, 2016 оны 1-5-р сар)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хуулийн заалт”:

25.8. Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эсхүл аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ.

“Хандив тусламжийг бүртгэх журам”

(Сангийн сайдын 2010 оны 3-р сарын 1-ны 45 тоот тушаалаар батлагдсан):

2.4.Хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгө, түүний зарцуулалтын талаар олон нийтэд зохих журмын дагуу мэдээлнэ.

“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”:

3.2. Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

3.2.7. хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тус тус цахимаар;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Хандив тусламжийн холбогдолтой мэдээлэл, баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн мэдээлэл, баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн мэдээлэл, баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгө, түүний зарцуулалтын 2015 оны хагас жилийн тайланг 2015 оны 8-р сарын 15-ны дотор, ШДЦХТМАНСТЖ-ын 6-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн байдал

Аймаг, нийслэл, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгө, түүний зарцуулалтын 2015 оны жилийн эцсийн тайланг 2016 оны 4-р сарын 25-ны дотор ШДЦХТМАНСТЖ-ын 6-р хавсралтад заасан маягтын дагуу Шилэн дансны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн байдал

Хавсралт 6. Судалгааны багийн талаарх мэдээлэл

Хөндлөнгийн үнэлгээний багийн гишүүдийн жагсаалт

- Л.Отгонтуяа, “Төсвийн удирдлагын хүрээлэн” ТББ-ын захирал, Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор
- Д.Цэрэнжав, “Ил тод байдал сан” ТББ-ын Гүйцэтгэх захирал
- Д.Оюунцэцэг, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор

Орон нутгийн судлаачдын жагсаалт

№	Аймаг	Байгууллагын нэр	Нэр
1	Архангай	"Мэдлэгийн сүлжээ" ТББ	Т.Хонгорзул
2	Баян-Өлгий	Албан журмын даатгагчдын холбооны Баян-Өлгий салбар	Х.Нуртилек
3	Баянхонгор	Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо	Н.Цэдэвсүрэн
4	Булган	"Булганы мэдээ" сонин	Г.Норжмаа
5	Говь-Алтай	Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл	Ш.Ариунаа
6	Говьсүмбэр	"Хөгжлийн Түншлэл" ТББ	Ч.Нарантуяа
7	Дархан-Уул	Аймгийн худалдаа аж үйлдвэрийн танхим	С.Мэндхүү Ж.Эрдэнэчимэг
8	Дорноговь	"Манлайлагч иргэд" ТББ	Д.Энхцэцэг
9	Дорнод	Улс төрийн боловсролын академи	Д.Мөнхзаяа
10	Дундговь	Аймгийн Иргэний нийгмийн сүлжээ, "Байгаль орчин, нутаг өлгий буян" холбоо	Б.Өлзийсайхан Б.Оргил-Эрдэнэ
11	Завхан	"Өрнөх Хөгжил" ТББ	М.Дуламжав
12	Орхон	"Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ	Б.Батцэцэг Б.Төгөлдөртуул
13	Өвөрхангай	Либерал эмэгтэйчүүдийн оюуны холбоо (ЛЭОС)	Ч.Ганцэцэг
14	Өмнөговь	Аймгийн нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд хөдөлгөөн	Б.Батжаргал
15	Сүхбаатар	"Сэтгэшгүй Оюундалай" ТББ	Э.Өлзийтогтох
16	Сэлэнгэ	Аймгийн ажил олгогч эздийн холбоо	Н. Энэбиш
17	Төв	Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо	Д.Оюун
18	Увс	"Сайн Тус" ТББ	Д.Тогтох Б.Сэлэнгэ

19	Ховд	Аймгийн нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд хөдөлгөөн	Д.Тогтуунбаяр Д.Дунчимэг
20	Хөвсгөл	“Хөвсгөлийн хөгжил дэвшил” ТББ	Б.Лхагваа
21	Хэнтий	Аймгийн ажил олгогч эздийн холбоо	Т.Эрдэнэбаатар Д.Аззаяа
22	Улаан-баатар	“Ил тод байдал сан” ТББ	Ц.Отгонсүрэн
23	Багануур	“Залуус манлайлал” ТББ	А.Өсөхжаргал М.Алтантуяа
24	Багахангай	“Энэрэл ач тус” ТББ	Ё.Ганцэцэг
25	Баянгол	“Хэрэглэгч сан” ТББ	Г.Оюунтуяа
26	Баянзүрх	“Хөгжлийн Хэлхээ” ТББ	А.Долгор
27	Налайх	“Налайхын амьдрал” сонин	Д.Батчимэг
28	Сонгино-хайрхан	“Захиргааны шинэ санаачилга”	С.Цэрэнпүрэв
29	Сүхбаатар	“Үнэн Хатамж” ТББ	Ж.Сайнзаяа
30	Хан-Уул	Монголын Төсвийн Мэргэжилтнүүдийн Холбоо	П.Байгалмаа
31	Чингэлтэй	“Урагш дэвших холбоо” ТББ	Х.Сувд